MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,160.597... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.08.28. Даваа. №142 (4756) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +15
Шөнө +1

УЛС ТӨР

П.СЭРГЭЛЭН: ГУРИЛЫН ҮНЭ НЭМЭГДЭХ ЯМАР Ч ҮНДЭСЛЭЛ БАЙХГҮЙ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ХЭНД НЬ ИТГЭХ ВЭ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Сүм, дуганаа цэвэр ариун байлгахсан

Э.ТУУЛ

Найр, хуримын сар үргэлжилсээр. Сайн өдрүүдийг харж, хувь тавилангаа холбож буй хосууд гэрлэх ёслол үйлдэхдээ сүсэгтэн олны хөлд дарагдсан сүм дуганаар орж, буян заяагаа даатгадаг нь ёс болсон гэлтэй. Түүгээр ч барахгүй тун удахгүй хичээлийн шинэ жилийн нээлт болж, оюутан сурагчид ч хэсэг бүлгээрээ нийлж аваад гандан гардаг нь уламжлал болж. Аялж яваа жуулчид ч манай нийслэлд ирэхдээ энэ л газруудаар орж, үзэх нь элбэг. Тэгвэл хэлэхгүй байж болохгүй нэг асуудал манай сүм дугануудад байх юм аа. Тодруулбал, тоосонд дарагдсан бурхан тахил, тортог болсон хадаг самбай, олны хөлөөр орж ирсэн шороо тоос энд үй түмээрээ байна.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# БИЕЭ, ГЭРЭЭ Ч ЗАССАН ХҮНИЙГ Л ТӨРД ОЙРТУУЛДАГ БАЙЯ

–Биеэ ч засч чадаагүй "бор халзан"–гууд төрийн нэр хүндийг унагаж гүйцлээ–



Н.ПУНЦАГБОЛД

МАН-ын 65-ын бүлгийн үед гишүүдтэй холбоотой янз бүрийн юм сонсож байна даа. Бүр УИХ-ын гишүүн хүчингийн хэрэгт нэр холбогдохыг хүртэл сонсдог л юм байна. Дахиад ч нэг гишүүн ийн асуудалд орооцолдсон талаар жиг жуг гэлцээд байгаа. Удахгүй нэр нь тодорхой болох юм байлгүй дээ. Ер нь өмнө нь ч гэсэн УИХ-ын гишүүд мөрийтэй тоглосон, хэрэг төвөгт холбогдсон, цаашлаад охид хүүхнүүдийг татаж чангаасан хэрэгт үе үе холбогддог л байсан.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр үндэсний чуулган зохион байгуулна

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилгаар "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр ирэх есдүгээр сард үндэсний чуулганыг зохион байгуулах гэж байна. Уг үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, Монголын хүнсчдийн холбоо, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хамтран зохион байгуулах юм байна. Монгол Улсын хүнсний салбарын өнөөгийн байдлыг тодорхойлох, хүн амын гол нэрийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж, шийдвэрлүүлэхэд "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр хийх үндэсний чуулганы зорилго оршиж байгаа аж. Үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ХХААХҮЯ, МХЕГ, ГЕГ зэрэг Төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоод, хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэн, судлаачид, газар тариалан эрхлэгчид, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл оролцоно. Үндэсний чуулганы өмнө салбар хуралдаанууд болох бөгөөд өнөөдөр Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, гахай, тахианы мах үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, 29-нд Сүү, ус, ундаа, тос үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, 30-нд Төмс, хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам сэдэвт салбар хуралдааныг тус тус хийхээр болжээ. "Монгол Улсын хүнсний аюулгүй байдал" сэдвээр үндэсний чуулган зохион байгуулснаар хүнсний салбарын хувийн хэвшилд тулгамдсан асуудлыг хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, төрөөс авч хэрэгжүүлэх шаардлагатай бодлогын арга хэмжээний саналыг боловсруулах, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг үр дүнд хүрнэ хэмээн зохион байгуулагчид үзэж байна.




**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2435.00 | 2452.00 | ФУНТ | 3117.00 | 3199.00 |
| ЕВРО | 2835.00 | 2900.00 | РУБЛЬ | 39.70 | 41.60 |
| ИЕН | 22.17 | 22.69 | ЮАНЬ | 363.50 | 367.40 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2428.00 | 2444.00 | ФУНТ | 3056.00 | 3178.00 |
| ЕВРО | 2825.00 | 2926.00 | РУБЛЬ | 39.69 | 43.32 |
| ИЕН | 21.70 | 22.68 | ЮАНЬ | 364.00 | 367.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## Удтал хүлээгдсэн төмөр замын шинэчлэлийн асуудлаар ярилцав

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн баасан гарагт ЗТХ-ийн сайд Д.Ганбат, УБТЗ нийгэмлэгийн дарга Д.Жигжиднямаа, МТЗ ТӨХК-ийн дэд захирал Б.Эрдэнэбаяр, ЗТХЯ-ны төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Артур нарыг хүлээн авч уулзлаа. Ерөнхийлөгч Х.Баттулгын есдүгээр сарын эхээр ОХУ-ын Владивосток хотноо зохион байгуулагдах Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцож, ажлын айлчлал хийх бэлтгэл ажилтай холбогдуулан энэхүү уулзалтыг хийсэн юм. Уулзалтын хүрээнд УБТЗ-ын удтал хүлээгдсэн шинэчлэлийн асуудлаар санал солилцон ярилцав. УБТЗ-ын үйл ажиллагааг шинэчлэхэд юуны өмнө 100 тэрбум рублийн зээл хэрэгтэй байгаа бөгөөд үүгээр нэн түрүүнд 467 км гол замыг хүчжүүлэх их засварын ажил, Салхит-Эрдэнэтийн 165 км төмөр замын засвар, Эмээлт-Хоолт, Хонхор орчмын бага радиустай 25 км тахир замыг шулуутгах зэрэг ажил хийх юм байна. Мөн техник хэрэгслийн парк шинэчлэл, цахилгаанжуулалт зэрэг олон ажил хийхээр төлөвлөжээ. Эдгээр ажлын хүрээнд модон дэрүүдийг бетон дэрээр солих, зөрлөг нэмэх, ачаа, сэлгээний зүтгүүрүүд, вагон нэмэх зэрэг олон ажил багтаж байгаа юм. УБТЗ-д шинэчлэл хийгдэлгүй удааширснаас ачаа тээвэрлэлт саатах, вагоны хомсдолд орох, ачааллаа дийлэхгүй байх зэрэг бэрхшээл учрах болжээ. Иймд одоо байгаа төмөр замын ганц коридороо даруй тордох ёстойг уулзалтын үеэр ярилцлаа. Уулзалтад ЕТГ-ын дарга З.Энхболд, Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх Л.Пүрэвсүрэн нар оролцов.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

САЙД ЯРЬЖ БАЙНА

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнтэй цаг үеийн асуудлаар ярилцлаа.*



# П.СЭРГЭЛЭН: Гурилын үнэ нэмэгдэх ямар ч үндэслэл байхгүй

**-Энэ зун гантай байснаас тодорхой хэмжээний ургац алдаж байна. Тэгэхээр цаашид алдсан ургацаа яаж нөхөж авах вэ?**

-Бид хаврын тариалалтаас эхлээд цаг агаарын урьдчилсан дүнгээр нарийн тооцоолж анхаарлаа хандуулж байсан. Энэ зун сүүлийн 60 жил тохиогүй их халалтаас болж гангийн нөхцөл үүсч, 40-50 хувийн ургац алдах нөхцөл үүссэн. Энэ асуудлаа бид яам, эрдэмтэд, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж судалгаа хийлгэсэн. Тиймээс бид сүүлийн нэг сарын хугацаанд ОХУ-тай хамтарч ажилласны үр дүнд дутагдаж байгаа үр, улаанбуудай авах хэлэлцээрээ амжилттай хийсэн. ОХУ-аас зах зээлийн үнээс хямд үнээр 170-200 мянган тонн улаанбуудай худалдаж авахаар тохиролцсон. Удахгүй тээвэрлэлтийн асуудлыг шийднэ.

**-Ургацын 40-50 хувийг алдсан гэхээр энэ жил гурилын үнэ нэмэгдэх болов уу?**

-Бид хэдий ургацын тодорхой хувийг алдсан ч ОХУ-аас зах зээлийн үнээс хямд үнээр улаанбуудай худалдаж авна. Дотоодын компаниудаас хямд үнээр авах учраас гурилын үнэ нэмэгдэх ямар ч үндэслэл байхгүй. Дотоодын хэрэгцээгээ хангах нөөц, боломж нь байхад гурилын үнэ нэмэгдэхгүй.

**-Цаг агаарын нөхцөл цаашид тийм ч таатай байхгүй нь. Ургац хураалтын үеэр хүндрэл гарч магадгүй байх шиг байна?**

-Тариаланчдад жил бүр олгодог шатахуун, тоног төхөөрөмжийн дэмжлэгүүд энэ жил олгогдоно. Тухайлбал, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас тариалан эрхлэгчдэд шатахууны хөнгөлөлттэй зээл олгох, тоног төхөөрөмж олгох ажил ид өрнөж байна. тариаланчдад ОХУ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр буюу таван жилийн хугацаатай тоног төхөөрөмжүүдийг олгож эхэлсэн. Мөн ургац хураалтын үеэр бүхий л талаар туслах, хүн хүч нэмэгдүүлэх, цаг агаарын таатай нөхцөлийг харж тариагаа хураах чиглэлээр тариалан эрхлэгчдэд зөвлөмж өгөх зэргээр хамтран ажиллаж байна. Цаг агаарын таатай нөхцөлийг ажиглаж байгаад ургац хураалтыг 10-14 хоногт багтаах төлөвлөгөөтэй байгаа.

**-Хадлан авч чадаагүй аймгуудын малчдын нөөцийг хэрхэн бүрдүүлэх вэ?**

-Жил жилийн дунджаас харахад малчид 1.2 сая тонн хадлан бэлтгэдэг. Энэ жил хэрэгцээт хадлангаа бэлтгэх бололцоо байхгүй учраас 400 мянга орчим тонн хадлан алдаж байгаа юм. Үүний тодорхой хувийг Сүхбаатар, Дорнод аймгаас бусад аймаг руу шилжүүлэх боломж бий. Тээвэрлэлтийн асуудал бага зэрэг хүндрэлтэй байгаа ч зохицуулах боломжтой. Харин баруун аймгуудын хадлангийн нөөцийг ОХУ-аас татахаас өөр арга байхгүй. ОХУ-ын талд ч 400 мянга орчим тонн хадлан авна гэдгээ мэдэгдсэн. Тэдний зүгээс нааштай хариу өгч байгаа.

**-Энэ жил ганд тэсвэртэй үр тарьсан учраас гантай жил сайн ургац авсан гэдгийг тариаланчид хэлж байсан. Ганд тэсвэртэй үрийг ирэх жил мөн тариалах уу?**

-Энэ жил тариаланчид маш сайн үрээр тариалалт хийсэн. Байгалийн давтагдашгүй нөхцөлд бид аргагүй ургац алдсан. Зүүн болон Төвийн бүсийн өмнөд хэсгийн 70 гаруй хувьд ч хур ороогүй. Байгалийн хүчин зүйл нөлөөлөөгүй бол тариаланчид маш сайн ургац авах байсан. 30 мянган тонн ганд тэсвэртэй үр нөөцөлж авахаар бэлтгэж байна. Нөөцийн үрээ ургац сайтай бүсээс бүрдүүлэх бодлого баримталж байна.

**-Тариалангийн бүс нутгаар энэ жил хэд хэдэн түймэр гарсан. Түймэр тариаланд нөлөөлсөн үү?**

-Гал түймэр тодорхой хэмжээнд тариалалтад нөлөөлсөн. Гал түймэртэй бүс нутаг үүл буудахад борооны үүл гарахгүй, үүлэнд нөлөөлөхөд хүндрэл үүссэн тал бий. Үүнтэй холбоотойгоор ургац алдахад нөлөөлсөн.

**-Газар тариалан, мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хэр хангагдаж байна вэ?**

-Монгол Улсын Засгийн газрын 2017 оны зургадугаар сарын 26-ний өдрийн 168 тоот тогтоол гарсан. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад 700 сая төгрөгийн төсөв гаргаж аймаг, орон нутгийн өвөлжилтийн бэлтгэлийг хангаж байгаа. Мөн 4.5 тэрбум төгрөгөөр өвч, хадлан, тэжээлд зарцуулахаар шийдвэрлэсэн. Орон нутагт аймаг тус бүрт 250-270 сая төгрөгийн төсөв гаргаж, өвөлжилтийн бэлтгэлээ хангахыг үүрэг болгосон байгаа. Энэ хүрээнд Засгийн газар, яам орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллаж, чиглэл өгч байна.

**-Малын халдварт өвчний тархалт зогссон уу. Өнгөрсөн долоо хоногт Дундговь аймагт халдварт өвчин гарснаас хорио цээр тогтоосон?**

-Малын халдварт өвчин нэмэгдэх гол шалтгаан нь отор, нүүдэлтэй холбоотой. Эрүүл бүсээс халдвартай бүсэд, халдвартай мал эрүүл бүсэд оторлох зэргээс үүдэлтэй халдварт өвчний тархалт буурахгүй байна. Яамнаас ажлын хэсэг гарч халдвар гарсан бүст яаралтай арга хэмжээ авч ажиллаж байна. Түүнээс гадна отор нүүдлийн асуудлыг зохицуулах албан даалгавар Ерөнхий сайд гаргасан.Малчид отort гарахдаа малаа эрүүл эсэхийг шинжлүүлэх, оторлох бүс нь мөн малын халдварт өвчний бүс эсэхийг сайтар шалгаж, зөвшөөрөл олгож буй. Зөвшөөрөл авсны дараа отор, нүүдлээ хийхгүй бол малчдад хүндрэл учирч болзошгүй. Тухайлбал, мал нь халдвартайг мэдэхгүй Сүхбаатар аймагт суурьшихаар очсон тохиолдол гарсан. Олон хоног цаг хугацаа алдаж оторлохоор очоод мал нь эрүүл биш учраас Сүхбаатар аймаг хүлээж аваагүй тохиолдол гарсан. Энэ мэтчилэн малчид хүндрэл учруулахгүй тулд малаа эрүүлжүүлэх шаардлагатай. Урьдчилсан байдлаар 2700 өрхийн 9,2 сая бусдын нутагт өвөлжихөөр байна. Гэхдээ наймдугаар сар гарснаас хойш бороо их орж, бэлчээрийн ургац нэмэгдэж байгаатай холбоотой отор, нүүдэл хийсэн малчид буцаад өөрийн нутаг руу нүүдэллэх талууд ажиглагдаж байна.

**-Мал эрүүлжүүлэх ажлын хүрээнд ОХУ-аас хөнгөлөлттэй үнээр вакцин авсан. Энэ вакциныг худалдаж авахад тодорхой хэмжээний хэмнэлт хийсэн гэж та хэлж байсан?**

-Би ажлаа аваад нэг жилийн хугацаа өнгөрч байна. Малын вакцин тойрсон маш их хэл ам, асуудал байсан. Хамгийн анхны худалдан авалтаа ОХУ-аас нэн хөнгөлөлттэй үнээр шууд худалдан авалт хийсэн. Энэ худалдан авалтаар бид дөрвөн тэрбум төгрөгийг хэмнэсэн. Мөн ОХУ-ын зүгээс дөрвөн тэрбум төгрөгийн өртөг бүхий вакциныг буцалтгүй тусламжаар олгосон. Эхний вакцин ирсэн бол дараагийн вакцинуудыг ес, арванхоёрдугаар саруудад авахаар тохиролцсон. Тэгэхээр бид нийт найман тэрбум төгрөгийг хэмнэж чадсан. Ийм хэмжээний хэмнэлт хийж чадаагүй бол улсын төсвөөс, татвар төлөгчдийн мөнгөнөөс найман тэрбум төгрөг гаргах байсан.

**-Махны экспорт энэ жил нэмэгдэх үү. Саяхан Саудын Араб Монгол Улсаас мах экспортлох санал тавьсан байсан?**

-Махны экспортын хэмжээ нэмэгдэж, тодорхой үр дүнтэй байна. Иран улсад Монголын хоёр үйлдвэр хоёр сая орчим толгой малын мах бэлтгэж, ачилтаа хийж байна. Иран улсаас мөн экспортолж буй махныхаа хэмжээг нэмэгдүүлж, долоо хоногт 4000 тонн мах авах саналтай байгаа ч дотоодын махны үйлдвэрүүдийн хүчин чадал хүрэхгүй байгаа. Вьетнам улстай гүн хөлдсөн мах экспортлох чиглэлээр баримт бичигт гарын үсэг зурсны үндсэн дээр хоёр вагон мах ачигдсан. ОХУ, БНХАУ-д хагас болон бүрэн боловсруулсан мах тодорхой хэмжээний мах экспортолж байна. Дотоодын махны үйлдвэрүүдийн хүчин чадлыг сайжруулах талаар хамтран ажиллаж байна. Саудын Арабын хунтайж Монгол Улсаас мах экспортлох саналаа албан ёсоор тавьсан. Энэ хүрээнд махны үйлдвэр хамтарч байгуулж ажиллахаа саналаа илэрхийлсэн. Хоёр талаас мах экспортлох, махны үйлдвэр байгуулах чиглэлээр ажлын хэсэг гараад ажилдаа орсон байна.

**-Монгол Улс тодорхой хэмжээний үхрийн мах импортолдог. Үхрийн махны импортыг бууруулах боломжтой юу?**

-Үхрийн махны импорт их хэмжээтэй биш. Дотоодын дээд зэрэглэлийн ресторанууд хоолныхоо стандарт шаардлагад нийцсэн үхрийн мах оруулж ирдэг. Монгол Улс дөрвөн сая үхэртэй. Бид олон үхэртэй биш ч үхрийн махны чанарыг сайжруулах, үржлийн бодлогод анхаарах, зөөлөн, чанартай мах боловсруулах тал дээр яам бодлого барьж байгаа. Үржлийн үхрийн өндөр хөгжилтэй орнуудаас оруулж ирэхээр худалдаж авахаар төсвийн тодотголд тодорхой төсөв суулгасан. Үхрийн фермийг төв суурин газар байгуулж өндөр зэрэглэлийн ресторануудын гадаадаас импортолж байгаа үхрийн махаар хангах бодлого баримталж байгаа. Бид жилд 150 мянга орчим тонн мах экспортлох боломжтой орон. Монгол Улс өөрөө хүнс, хоол зэрэг жижиг дунд үйлдвэрлэлийг бид өөрсдөө хийх ёстой. Яамны зүгээс эхний ээлжинд бид дотоодын хүнсний хэрэгцээг хангаж, цаашид экспортод гаргах талаар бүх салбарт ажиллах ёстой.

**-Нөөцийн мах бэлтгэх үү?**

-Нөөцийн мах худалдан авах чиглэлээр тодорхой хөрөнгө улсын төсвөөс гаргасан. Өвөлжилт хүндэрч болзошгүй аймгуудын малчдын махыг төр худалдаж авна. Мөн өвс бэлтгэхэд хүндрэлтэй бүсийн малчдын махыг өвсөөр солих тодорхой шийдвэрүүд гарсан.

**-Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд төрийн дэмжлэг маш их дутагддаг. Энэ жил жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ялангуяа хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжихэд ямар бодлого баримталж байна вэ?**

-Жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл олгож буй. Улсын төсөвт мөнгө суулгаж чадаагүй ч өмнөх зээлийн эргэн төлөлтөөс тодорхой хөрөнгө оруулалтыг хийж байна. тухайлбал, ажлын байраар хангах, тоног төхөөрөмж, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч байна. Мөн Засгийн газраас бодлогын зээлийг жижиг, дунд үйлдвэрийн салбарынханд олгож байгаа. Зээлийн эх үүсвэр дутагдалтай, зээлийн эргэн төлөлт удаашралтай байгаа хүндрэлүүд үүсч байгаа ч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Өмнөх онуудтай харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалт буурсан. Засгийн газар зөв бодлого явуулсны хүчинд хөрөнгө оруулалт эргээд сэргэж байна. Гадаадын компаниуд хамтран үйлдвэр байгуулах, хамтран ажиллах саналууд ирж байна. Засгийн газар гадаадаас орж ирж байгаа хөнгөлөлттэй зээл, тусламжийн чанар, үр дүн өгөөж нь Монгол Улсад, дотоодын аж ахуйн нэгжид хэрхэн тусах вэ гэдэгт онцгой анхаарч байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## RIMES-тай хамтарсан төсөл хэрэгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийллээ

Папуа Шинэ Гвиней Улсын Порт Моресбей хотноо энэ сарын 23-25-ны өдрүүдэд Ази-Африкийн бүсэд байгалийн олон төрлийн гамшгаас урьдчилан сэрэмжлүүлэх нэгдсэн систем /RIMES/-ийн Удирдах зөвлөлийн IX хурал, RIMES-ийн гишүүн орнуудын Сайд нарын III хурал болж, манай улсаас БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Г.Нямдаваа тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Хурлаар Ази-Африкийн бүсэд байгалийн олон төрлийн гамшгаас урьдчилан сэрэмжлүүлэх нэгдсэн системийн (RIMES) 2016-2020 оны мастер төлөвлөгөөний хэрэгжилт, гамшгийн эрсдэлийг багасгах үүднээс хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ус цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээг шийдвэр гаргагчдад хэрхэн шуурхай хүргэх тухай хэлэлцсэн байна. Мөн RIMES-аас гаргаж буй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээг хэрхэн бүсийн төвүүдээр дамжуулан хүргэх, гишүүн орнууд байгалийн гамшгийг хэрхэн бага хохиролтойгоор даван туулах, Папуа Шинэ Гвиней Улсад RIMES-ийн бүсийн төвийг шинээр нээх зэрэг асуудлыг хөнджээ. Энэ үеэр Монголын төлөөлөгчдийн тэргүүн Г.Нямдаваа Сайд нарын түвшний хуралдаанд үг хэлж, БОАЖ-ын сайд Д.Оюунхоролын мэндчилгээг дэвшүүлэн, Монгол оронд ажиглагдаж буй байгалийн гамшигт үзэгдлүүд, түүнийг хэрхэн хохирол багатайгаар даван гарах, RIMES-ийн үйл ажиллагаанд Монгол Улсын оролцох оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, RIMES-тай хамтарсан төсөл хэрэгжүүлж ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийллээ. RIMES нь олон улсын байгууллагын статустай, НҮБ-ын Засгийн газар хоорондын албан ёсны нэг хөтөлбөр болон 102 дугаартайгаар бүртгэгдсэн бөгөөд одоогийн байдлаар Ази-Африкийн 18 улс нэгдэн орсон бөгөөд 20 гаруй орон ажиглагчаар оролцож байна. RIMES-ийн гол зорилго нь хил дамнасан байгалийн олон төрлийн гамшгийн хор хөнөөлийг багасгах, түүнээс урьдчилан сэрэмжлүүлэх үйлчилгээг үзүүлэх, цунами болон бусад байгалийн гамшгаас урьдчилан сэрэмжлүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдэж байна. Хуралд Ази-Африкийн 42 орны төлөөлөгчид болон Ази–Номхон далайн эдийн засгийн комисс (ESCAP), Дэлхийн цаг уурын байгууллага зэрэг олон улсын таван байгууллагын төлөөлөгчид оролцож байгаа юм. RIMES-ийн Сайд нарын хурлаас цаашдын хамтын ажиллагааны талаар зөвлөмж гарган батлав.

## ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт "Тангарагийн баяр"-т оролцлоо

ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт Хууль сахиулах их сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн цэргийн анхан шатны сургалтад суралцсан сонсогчдын "Тангарагийн баяр"-ын ёслолын үйл ажиллагаанд оролцлоо. Энэ жилийн цэргийн анхан шатны сургалтад 370 гаруй сонсогч хамрагдаж, өнөөдөр ийнхүү аав ээж, ах дүү, эрдэмтэн багш нарынхаа өмнө эх орныхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэхээ тангараглав. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт "Тангарагийн баяр"-ыг нээж хэлсэн үгэндээ "Хууль Сахиулахын Их сургууль бол эрх зүйт төрийн үрийг суулгаж, үндсийг бэхжүүлж буй эрдмийн их хүрээлэн билээ. Тус сургууль Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг байгууллагууд болон онцгой байдлын байгууллагад мэргэжлийн мэргэшсэн, өндөр чадамжтай хүний нөөцийг бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр нөлөө, өгөөжийг дээшлүүлэн, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан боловсон хүчин бэлтгэх зорилгоо нэр төртэй биелүүлж байгаад баяр хүргэе. Түүнчлэн өргөсөн тангаргаа санаж ээж аав, эх орон, ард түмнийхээ итгэл сэтгэлийг бодож, нойронд сэргэг, номонд мэргэн байж, эрдэмтэн багш нарынхаа заасан эрдэмд шамдан суралцаж, их эрдмийн оргил өөд үргэлж тэмүүлж байхыг сонсогчдод хичээнгүйлэн захиж байна" гэлээ. Жил жилийн "Тангарагийн баяр"-ын үйл ажиллагаанд маш олон хүн хүрэлцэн ирдэг. Энэ жил ч орон нутаг, нийслэлээс зорин ирж хүүхдийнхээ тангараг өргөхийг харж, сэтгэл догдлон суугаа эцэг эх, найз нөхөд, хамаатан садан олон байлаа. ХЗДХ-ийн сайд сонсогчид ямар нөхцөлд сурч, амьдарч байгаатай танилцав. Яамны зүгээс Хууль сахиулах их сургуульд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тодорхой асуудлыг шийдвэрлэж, сонсогчдын сурах нөхцөл боломжийг сайжруулсан гэдгийг сургуулийн удирдлагууд хэлж байсан юм. Хууль сахиулах их сургууль нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг байгууллагууд болон онцгой байдлын байгууллагын эрэлт хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг гэдгээрээ онцлогтой юм.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Сүм, дуганаа цэвэр ариун байлгахсан

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гадна байрлах хүрднүүд ч эргүүлэхийн эцэсгүй хир даг болчихсон нь зарим хүний сэжгийг хүргэдэг талаар хэлж байх юм. Цаашлаад сүсэгтэн олон сүм, дуганд ирэхдээ дуганы хана, үүдэн дэх арслан, хүрдэн дээр шар тос нялж, шар, цагаан будаа цацаж, өнөөх нь халуунд үнэр танар нь ч дийлдэхээ больчихдог юм байна билээ. Төв ганданд маань байх Жанрайсаг бурхан маань ч тоос шороонд дарагдаж, өнгө нь гунджээ. Өлгөсөн таван өнгийн торго, эргэн тойрных нь бурхад ч тоосонд дарагдчихаж. Угтаа бол Гандантэгчинлэн хийдээр орж гарч буй хүмүүс Жанрайсаг бурханд мөргөж, буян заяагаа даатгадаг шүү дээ. Тиймээс л энэ шүтээний газар маш ариун, цэвэрхэн байж гэмээнэ хүний сэтгэлд ариун номын орноор төсөөлөгдөж, сүсэглэх нь дамжиггүй. Гэтэл тэнд сүсэглэх нь бүү хэл сэжиглээд гарах хүний тоо сүүлийн үед нэмэгдэж байна. Дээр хэлснийг батлах хэд хэдэн хүний яриаг ч сонслоо. Тухайлбал, нэг танил маань “Жанрайсагийн шалыг нь хоёр жилийн өмнө үнэ төлбөргүй нэг удаа угаалгын тоног төхөөрөмжөөр цэвэрлэж өгч билээ. Хариуцсан хүмүүс нь нэг ч удаа ингэж цэвэрлэж байгаагүй гэж байсан. Жанрайсаг бурхнаа тойроод нил тос өөх. Цэвэрлэхэд хэцүү л юм билээ. Уг миний санаа бол цэвэрлэгээний тоног төхөөрөмж аваад хийчихвэл зүгээр гэж ойлгуулах гэсэн ухаантай. Гэтэл харуул нь шал согтуу, өөдөөс томроод угаах ус ч олоод өгөөгүй шүү. Тэдний яриагаар бол мөргөлчдийн өргөж буй мөнгийг хийдэг гурван хайрцагнаас сардаа сая төгрөг өлхөн олдог гэсэн. Цэвэрлэгээ хариуцсан эмэгтэй хогийг нь л шүүрддэг гэж байна билээ. Гандангийн удирдлагууд нь ер санаа тавьдаггүй гэж гомдоллож суусан” гэж ярьсан юм. Харин нөгөө нэг танил маань “Тавдугаар сарын үед Бутанаас ирсэн хэдэн зочин дагуулаад Гандан орсон юм. Жанрайсаг бурхан байдаг дуган руу орох гэтэл манай зочид гутлаа тайлаад эхэлсэн. Тухайн үед маш хүйтэн байсан болохоор та нар гуталтайгаа ороход болно, бид гутлаа тайлдаггүй юм гэсэн чинь маш их гайхаж, ийм ховор шүтээний танхимд уу гээд толгой сэгсэрч билээ. Тэгэхэд их ичсэн шүү. Ганц гандан ч биш Эрдэнэзуу хийд ч гэсэн тийм олон жуулчин хүлээж авдаг газар хэрнээ жилийн жилд нэмсэн нэг ч зүйл байхгүй, ядаж зэрлэгийг нь ч зулгаагүй харагддаг. Уг нь Бурхны зарлиг судart хиртэй гараар хүрч болохгүй, бохир газар байлгаж болохгүй гэсэн байдгийг бүх лам нар, сүсэгтнүүд мэдэж байх учиртай л юмсан” хэмээн халаглаж байсан удаатай. Үнэндээ гандан хийдүүдэд маш олон лам хуварга бий. Тэд бурхан номын төлөө, бусдын төлөө амьдралаа зориулна хэмээж сахил хүртсэн болохоор эрхэлсэн ажилдаа эзэн ёсоор хандах л ёстой. Гэвч бодит байдал дээрээ тийм биш байна. Бурхан шүтээнийхээ тоосыг өдөр болгон биш юм гэхэд сардаа нэг удаа цэвэрлэчихэж болмоор доо, уг нь. Ганданд ном хуруулахад гаргасан тариф гээд өндөр үнэ зоочихсон самбар харагддаг. Гэтэл өгч буй үнэ өртөгтөө таартал ариусч, гэгээрээд гарах нь юу л бол. Зарим хүний хэлж буйгаар бараг бичүүлсэн номыг маань уншиж байгаа эсэхийг ч мэдэхгүй, ямар ч байсан ном бичүүлсэндээ л гэж боддог гэх. Тэгэхээр авч буй үнэ өртгөө бодсон ч, ариусч гэгээрэх гэж очиж буй сүсэгтнүүдийг бодсон ч сүм, дуганы удирдлагууд минь ариун, гэгээн орчныг бүрдүүлж, бурхан шүтээнээ цэвэр ариун байлгах л хэрэгтэй байна. Гадны сүм хийдүүдийг гандангийн лам нар маань очиж үзээ л байлгүй дээ. Сүсэгтэн олныг хөл нүцгэн оруулж, сүм хийдээ шил толь болтол цэвэрлэчихсэн байдгийг нь гадарлах л байх. Бараг худалч хүнд шалыг нь долоохад ч болохоор тийм л цэвэрхэн, гоёмсог байдаг. Лам нар нь ч хар үүрээр босоод л бүгд цэвэрлэгээний ажил хийж, бурхан шүтээнээ өнгөлж зүлгэдэг юм билээ. Гэтэл манай сүм хийдүүд ариун гэгээн газар шиг санагддаг бил үү. Хаалга үүднээсээ эхлээд л бурхан шашинтны төв гэдгээ илэрхийлэх, хүн орохдоо ч сүсэглэн бишрэх ёстой тэр л газар бол гандан. Гэтэл манай гандан хийдүүдийн гадна хаалганых нь шавар шохой нь хуураад уначихсан, шээс шивтэр үнэртсэн, халцарч муудаад хариугүй нурж унах нь уу гэмээр харагддаг нь худлаа биш ээ. Хашаан дотроо ч авах юмгүй. Ямар машин тэрэг оруулдаг биш. Сайхан зүлэгжүүлээд, мод бут тарьчихад болохгүй нь юу байх вэ дээ. Одоогоос хоёр, гурван жилийн өмнө Дашчойлин хийдийн нэгэн хамба “Жилд сүсэгтэн олны хандиваас 600 гаруй сая төгрөгийн орлого ордог. Үүнийхээ 500 гаруй сая төгрөгийг нь лам нарын цалин, цахилгаан зэрэгт зарцуулаад, үлдсэнийг нь жил бүрийн засварын ажилдаа зориулдаг” гэж ярьж байсан юм. Тус хийдэд ном хуруулсан сүсэгтэн олон өнөөдрийг хүртэл ямар нэг тогтсон тарифгүйгээр өөрийнхөө сүсэг бишрэлээр л өргөлөө өгдөг. Тэгэхэд л ийм их орлоготой байгаа юм чинь тариф тогтоосон Төв гандан маань бүр ч ихийг олдог нь мэдээжийн хэрэг. Тиймээс л шаардлага тавиад байгаа юм. Төв гандангийн удирдлагууд сэтгэл гаргаж, сүм дуганаа ариун дагшин бурхны орон болгохгүй бол аялал жуулчлалын жишиг бүс болгоод яах ч юм билээ дээ.

## Биеэ, гэрээ ч зассан хүнийг л ТӨРД ОЙРТУУЛДАГ БАЙЯ

**–Биеэ ч засч чадаагүй “бор халзан”–гууд төрийн нэр хүндийг унагаж гүйцлээ–**

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гишүүний халдашгүй эрх энэ тэр гээд л тэгсгээд өнгөрдөг. Хохирсон хүмүүс нь хэдэн төгрөг аваад салдаг ч байсан байх. Харин энэ удаад бол УИХ-ын хамгийн залуу гишүүн гэх тодотголтой Д.Гантулгын холбогдсон хэрэг өндрөө авчихлаа. Түүнийг хууль хяналтын байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгахаар болсон. Хохирогч эмэгтэйн эгч өнөөдрийг хүртэл асуудлыг өөрийнхөө хэмжээнд, нотлох баримттайгаар дэлгэж, олон нийтэд харуулсаар байгаа. Мөн намынх нь нэр хүндийг унагасан хэмээн МАН-ын зарим гишүүд түүнийг нэр төртэйгээр шалгуулахыг ч шаардсан. Ямар ч байсан түүний хэргийг шалгахаар болсон. Тэр ч битгий хэл УИХ-ын гишүүн Д.Гантулгад хүчиндүүлсэн гэх эмэгтэйн өргөдөл, гомдлыг анх хүлээн авч шалгасан Баянзүрх дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн мөрдөн байцаагч нарыг АТГ-аас шалгаж эхэлсэн гэх мэдээлэл ч цацагдаад байгаа. Энэ бүхнээс харахад, Д.Гантулга гишүүний хийсэн хэрэг бараг нэг талдаа гарчихаж байгаа юм биш үү. Одоо асуудал эцэслэн шийдэгдэхийг л хүлээх үлдэж байна. Ер нь бол мань хүн өөрийнхөө орооцолдсон асуудлыг яая даа гэж байж бас Засгийн газрыг унагахаар гарын үсэг цуглуулсан хэдтэй нийлчихсэн тууж явсан. Дотуур өмдөө хаана тайлахаа ч мэдэхгүй, хаана хамаагүй айлд хонож яваа хүн Засгийн газрыг унагах эсэхийг шийдэлцэх гэж байгаа нь харамсалтай биш үү. Угтаа бол одоо УИХ-ын Ёс зүйн дэд хороо хуралдаад, мань хүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхэд л хэргийг эцэслэн шалгаад, мөрдөн байцаагаад, буруутай эсэхийг нь нарийн шалгачихна. Тэгээд ч Д.Гантулга буруутдаг ч байлаа, эсвэл зөвдсөн байсан ч гэсэн эцсийн эцэст Монголын төрийг самарчихлаа. УИХ-ын гишүүн юу дуртайгаа хийдэг төрд ийм л хүмүүс шургалдаг болж гэж ард түмэн бодож эхэлсэн. Юун төрийн сүлд өршөө гэж цай сүүнийхээ дээжийг өргөх. Төрийн ордонд “Би бандаашаа өмсөөд гарсан” гэж дотуур хувцасны хэрүүл хийж байгаа нөхдүүдийг үзэн ядаж, нийт гишүүдийг түүгээр төсөөлөх дээрээ тулчихлаа. Төрийн нэр хүнд унаж байсныг үгүйсгэхгүй. Одоо бол бүр шороотой хутгалдаад эхэллээ. Тэр хутгах ажлыг нь биеэ ч засч чадаагүй “шинэков”-ууд л хийж байна. Эхнэр хүүхэдтэй хүн байж хүүхэн дагуулж саун хэсээд л. Дараа нь өнөөх хүүхэнтэйгээ айлд очиж хоноод. Тэгээд болоогүй бас гэрийн эзнийг нь хүчиндсэн хэрэг холбогдоод ч байх шиг. Чуулган тасалсан тоогоороо тэргүүлнэ. Хуралд суугаагүй шалтгаанаа тэнд байгаад хэрэггүй мэтээр тайлбарлана. Эмэгтэй сэтгүүлчтэй утсаар ярихдаа “Хүүхэд хийгээд өгье” энэ тэр гэж ангалзана. Тэр бичлэгээ эвлүүлэг гэж гүрийдэггүй л юм бол шүү дээ. МАН өнгөрсөн сонгуулиар 65 суудал авсны 40 гаруй нь шинэ гишүүн гээд байгаа. Яах вэ, шинэ гишүүд дунд мэдлэгтэй, чадвартай, өмнө нь төрийн байгууллагад ажилласан туршлагатай, эдийн засаг, хуулийн өндөр мэдлэгтэй нь бий. Харин төрийн нэр хүндийг унагаж гүйцэж байгаа нь ч цөөнгүй. Өмнөговь аймгаас сонгогдсон Н.Амарзаяа гэдэг гишүүн бий. Монголчууд бүгдээрээ түүнийг сайн таньдаг болсон байх. Учир нь эрхэм гишүүн хурал дээр хээвнэг бөхь зажилна. Төрийн дуулал явж байхад утсаар яриад ярвайж зогсох. Сонгогчидтойгоо уулзахаараа зад загнана. “Та нар одоохондоо миний ажлыг дүгнэх болоогүй байна” ч гэж байх шиг. Бүр “Та нараас гуйж сонгогдоогүй” гэж ч аархаж байсан. Тэгээд сүүлдээ “Би олны анхааралд өртдөг гэдгээ одоо л мэдэрлээ” гэх маягийн зүйл яриад сууж байсан. Гэх мэтээр “шинэков”-уудын талаар бичээд, жишээ татаад байвал дуусахгүй их. Ер нь 30 гаруй насны, 40 хүрээгүй залуучууд төрд орж ирээд яаж ажиллаж байна вэ гэдгийг МАН-ын шинэковууд хангалттай харуулж байна. МАН-ын түүхэнд анх удаа Засгийн газраа намынхан нь өөрсдөө унагах гэж байгаа тохиолдол одоо л гарч байна. Гэтэл Ерөнхий сайдыг унагах бичигт гарын үсэг зураад явж байгаа гишүүдийн ихэнх нь шинэ суралцагсад байгаа юм. Тэд өөрсдөө толгой мэдсэн үү гэвэл бас эргэлзээтэй. Бусдын үгээр л амаа залуулж, толгойгоо мэдүүлж яваа шүү дээ. Тиймээс УИХ-ын гишүүн, цаашлаад Ерөнхийлөгчид өрсөлдөх хүний нас, шалгуурыг ч нэммээр байгаа юм. Эрх баригч намынхны одоо хийх гээд байгаа гол ажлын нэг нь Үндсэн хуульд өөрчлөлт оруулах. Тэр дунд шүүгчийн насыг нэмэх гэж байгаа юм билээ. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд УИХ-ын гишүүний насыг нэммээр байна. Залуучууд орж ирээд Төрийн ордонд бандааш яриад зогсч байна шүү гэдгийг хэлсэн. Яах аргагүй үнэн. Одоо бол 25 нас хүрсэн хүн УИХ-ын гишүүн болох боломжтой. Ердөө л нас заасан. Өөр шалгуур байхгүй. Өөр шалгуур тавина гэхээр хүний сонгох, сонгогдох эрхийг арай хэтэрхий зөрчсөн болох байх л даа. Гэхдээ ядаж УИХ-ын сонгуульд өрсөлдөх эрхтэй насыг нь 35 болгочихмоор байна шүү дээ. Гэтэл одоо гэрээ битгий хэл биеэ ч засч чадаагүй нөхдүүд саарал ордонд бандааш яриад, бохь зажлаад сууж байна. Манайх л хүний эрх энэ тэр гэж сүржигнээд байгаа болохоос биш хуучин цагаас суралцах зүйлс их бий. Ядаж л гэр бүл нь тогтвортой, нас намбатай, боловсролтой хүмүүсийг даргын албанд томилдог байсан биз дээ, хуучин цагт. УИХ-ын гишүүн болох хүнд ядаж тийм ч болов шалгуур тавибал ядаг юм. Ёс зүйн доголдол гаргахааргүй, УИХ-ын гишүүн гэдэг бол өндөр ёс зүйтэй, алхам тутамдаа төрийн нэр хүндийг өндөрт өргөж, ард түмнийхээ төлөө зүтгэх алба ёстой гэсэн шалгуур ч тавих л ёстой. Түүнээс биш хүн л юм чинь тэгэх ч ёстой, ингэх ч эрхтэй гээд төрийн ордонд согтуу яваад, түүнийгээ даралтны эм гэж тайлбарлаад. Хаана хамаагүй боорцог идээд л, цайгаа ч уух завгүй байсан юм гээд байх ч шаардлагагүй. Тэгээд ч 30 гаруйхан настай эрэгтэй гишүүд УИХ-д суухаар охид хүүхний асуудал нь ч дуусахгүй юм. Тийм болохоор Үндсэн хуульд өөрчлөлт оруулах бол үүнийг жаахан анхаарч үзмээр байна. Тэгээд намууд нэр дэвшигчээ сонгохдоо “бор халзан хонь” биш жаахан мэдлэгтэй, туршлагатай, хариуцлагатай хүнийг сонгомоор юм. Тэгэхгүй бол намынхаа, цаашлаад төрийн нэр хүндийг шавартай хутгаад дуусах нь байна.

> ...Ер нь бол мань хүн өөрийнхөө орооцолдсон асуудлыг яая даа гэж байж бас Засгийн газрыг унагахаар гарын үсэг цуглуулсан хэдтэй нийлчихсэн тууж явсан. Дотуур өмдөө хаана тайлахаа ч мэдэхгүй, хаана хамаагүй айлд хонож яваа хүн Засгийн газрыг унагах эсэхийг шийдэлцэх гэж байгаа нь харамсалтай биш үү...

ӨӨР ӨНЦӨГ



## Хүрэлсүх үү, МАН уу?

Б.СЭМҮҮН

Өнгөрөгч долоо хоногийн гол сэдэв “У.Хүрэлсүхийг хэн тагнасан бэ?” гэдэгт хариулт өгөх явдал байлаа. Гэвч нэг мэдэхэд асуултын байр солигдоод “Хэн шалгасан бэ?” болоод явчихав. Одоо маргаан МАН-ын хүрээнээс хальж, АТГ, ТЕГ гэх мэт мөрдөн шалгах байгууллагууд руу чиглээд ирлээ.

Эргэн санахуй... Ердөө сар шахмын өмнө наймдугаар сарын 2-нд Шадар сайд У.Хүрэлсүх нэгэн ноцтой мэдээллийг нийтэд дэлгэсэн дээ. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захиалгаар МАН-ын байрны хамгаалалтын албаны залуус түүнийг мөрдөн мөшгиж, амь насанд нь халдах оролдлого хийсэн тухай. Мэдээлэгч тал л өөрөө “амь насанд заналхийлж байна” гэж сүржигнэснээс биш үнэндээ бол “Цаадахдаа ганц шанаадуулаад хэдэн төгрөг авчих аа, бид ар талыг нь даая. Бүр дээрээс, Ерөнхий сайдаас ирсэн үүрэг шүү” гэсэн утгатай утасны яриаг сошиалаар тарааж, төлбөрийн урьдчилгаа аваад уг ажиллагаанд оролцсон цагдаагийн хуучин ажилтан “Эцэстээ С.Зоригийн аллага шиг зүйл болох вий, хэн нэг нь Шадар сайдын аминд халдах вий гэж болгоомжилсны улмаас би энэ ажлаас татгалзаж, хэргийг илчилсэн. Гэвч Монгол Улсын Ерөнхий сайдын харьяанд ажилладаг ТЕГ энэ хэргийг шалгахгүй байна” хэмээн ярилцлага өгчээ. Өнгөрсөн сонгуулийн өмнө “иргэн” Доржзодовын задалсан 60 тэрбумын хэрэгтэй зохиомжийн хувьд тун ойролцоо. Сонгуулийн өмнө тавдугаар сарын 7-нд үүрэг өгөгдөж, 17-нд цуцлагдсан гэх мөрдлөгийн талаар бараг хоёр сар хагасын дараа наймдугаар сарын сарын 2-нд олон нийтэд мэдээлжээ. Ажиллагаанд оролцогчдын нэг нь мэдээллийг дотроосоо задалсан тэр үед М.Энхболд сонгуульд ялах эсэх нь тодорхойгүй байсан учраас өгөгдсөн үүргийг цуцлаад сонгуулийн үр дүнг хүлээсэн бололтой юм.

Шадар сайдын ажлын албаныхан наймдугаар сарын 2-нд хэргийн талаар мэдээлэл хийхдээ “ТЕГ нь Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын шууд удирдлагад ажилладаг, хэргийн талаар удаа дараа мэдээлэл өгөөд байхад шалгахгүй байгаа учраас АТГ-т хандаж уг хэргийг шалгуулна” гэсэн билээ. АТГ-ынхан У.Хүрэлсүхийг “тагнасан” Ж.Эрдэнэбат сайдын хэргийг шалгаад “У.Хүрэлсүх гэдэг хүн өөрөө энэ хэргийг зохион байгуулж, зориудаар бичлэг хийгээд тараасан байна аа. Ж.Эрдэнэбат гэх хүн энэ хэрэгт холбоотой нь тогтоогдсонгүй” гэдэг мэдээллийг өнгөрөгч баасан гарагт хийв. У.Хүрэлсүх сайд уг хэргийг зохион байгуулахдаа өөрийн дүү н.Отгонбаяр, н.Амарсанаа нарыг оролцуулан өөрийгөө зориудаар мөрдөж мөшгүүлсэн, эвлүүлэг, бичлэг хийж тараасан нь тогтоогдсон тул “төрийн эрхийг хууль бусаар авах гэсэн” зүйл ангиар яллагдагчаар татаж, прокуророоос зөвшөөрөл авахаар хүсэлтээ хүргүүлсэн гэв. Харин орой нь Шадар сайдын ажлын албанаас сэтгүүлчидтэй уулзаж, “АТГ хэт нэг талыг барьсан улс төрийн зорилготой ажиллаж байна. Төрийн өндөр дээд албан тушаалтнууд хууль, хяналтын байгууллагуудыг улс төрийн зорилгодоо ашиглаж байна” гэв. Уг нь “Баяраа өөрөө л уначихсан” юм билээ л дээ.

Хуулийн байгууллагад шалгагдаж байгаа хэргийн эцсийн үр дүнг мэдээж хуулийн байгууллага нь эцэслэн тогтоох биз. Харин үүнээс наана бий болсон улс төрийн нөхцөл байдал илүү анхаарал татна. Тухайлбал, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнийн хэлсэн үг...

Өмнө цацагдсан бичлэгт /”Херо” Баатарын утсан дээрээ бичээд алдсан гэх/ “Херо” Баатар сонгуулийн дараа У.Хүрэлсүх сайд руу залгаад “Тулгыгаа Ерөнхийлөгч болгочихлоо. Одоо тань дээр ажиллана аа. Тулга танд их баярлаж байгаа шүү. Оюун-Эрдэнэ ахыг байлцуулаад хэдүүлээ уулзья. Сая бол та манай хүнийг тултал дэмжлээ шүү дээ. Одоо ах дээрээ /У.Хүрэлсүхийг хэлж байна/ ажиллана аа” гэсэн нь У.Хүрэлсүхийг Ерөнхийлөгчийн сонгуулиар намынхаа эсрэг ажиллажээ гэсэн дүгнэлтэд хүргэсэн билээ. Үүний дараа У.Хүрэлсүх Шадар сайдын албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Харин өнгөрөгч долоо хоногт Л.Оюун-Эрдэнэ гишүүний намынхандаа хэлсэн үг бас л гайхамшиг болов. МАН-ын залуу гишүүн “Тэгвэл Баатар ахын М.Энхболд даргатай ярьсан бичлэгийг тавьчихья л даа” гэж намынхнаа дарамталжээ. Тэгэхээр “Херо” Баатарын бичлэгүүд задарч дуусах яагаа ч үгүй бололтой. Гэхдээ зорилго нь юунд вэ? гэдэг асуулт.

Сураг дуулахнээ Л.Оюун-Эрдэнэ гишүүн өнгөрсөн сонгуулиар намынхаа нэр дэвшигчийн пиарын багийг ахлаж ажилласан юм билээ. Өөрөөр хэлбэл, сурталчилгааны хугацаанд М.Энхболдын штабаас түгээж, олон нийтийн зүгээс шүүмжлэл, эсэргүүцэлтэй тулгаран хад мөргөж байсан олон “мессэж”-үүд мань хүний гараас гардаг байж. Сүүлд хэлсэн үгээс нь үзвэл Л.Оюун-Эрдэнэ гишүүн нэр дэвшигчийнхээ эсрэг ажиллаад зогсохгүй хувийн яриаг нь бичлэг хийж хадгалдаг байсан байна. Хожим өөрийнх нь эсрэг ашиглахын тулд...

Товчхондоо эцэг нэгтэй ах, дүү хоёр Монголын улс төрийг тодорхойлж, АН, МАН дотор хэнийг нь дээш, доош явуулахаа шийддэг болсон байна л даа. Гэхдээ арга барил нь их муухай. Манай намын залуус юу болоод байна аа... гэж Д.Хаянхярваа гишүүний дуу алддаг нь ч аргагүй. Тэдний дотор туршлагатай улстөрч, МАН-ын ирээдүй гэж зарим нэгэнд харагддаг байсан Шадар сайд У.Хүрэлсүх тэргүүнд нь явж байдаг нь бүр ч тоогүй.

Уг нь У.Хүрэлсүх гэдэг хүн МАН-д сайн ч зүйл ихийг хийсэн, муу ч их хийсэн. Алдаатай ч, оноотой ч нэгэн. Тэр утгаараа энэ нам дотор өөрийн дураар амьсгалдаг цөөхөн эрхмийн нэг. Одоо хийж буй үйлдэл нь ч гэсэн зөвхөн У.Хүрэлсүхээс л гарч болох араншин юм даа. М. Энхболдоос МАН-ыг салгахын тулд чөтгөртэй ч эвсэхэд бэлэн гэж байна. Уг нь М. Энхболдоос томилолт авч Ж.Эрдэнэбатын танхимд сайдаар багтсан хүн. Одоо харин “Албан тушаалаа өгч байгаад та нартай нэгийгээ үзнэ ээ” гэж байгаа. МАН дотор өрнөж буй үйл явлуудаас үзвэл замд нь хөндөлссөн юуг ч хуйхлахад бэлэн байгаа бололтой. Тэр нь МАН ч байсан хамаагүй юм байна л даа. МАН дийлэх үү, У.Хүрэлсүх дийлэх үү? МАН үлдэх үү, У.Хүрэлсүх үлдэх үү? гэдэг асуултыг тавиад зүтгэж байна. Эрүүл саруул, нэр төртэй улстөрч бол энэ тохиолдолд эхнийхийг нь сонгодог. Ядаж л хоёр дахь боломжоо авч үлдэхийн тулд. Харин У.Хүрэлсүх, Л.Оюун-Эрдэнэ нарын хувьд өөр байр суурьтай явдаг бололтой. Намын даргын суудлыг авахын төлөө тэдний эхлүүлсэн дайн МАН-ыг хаа хүртэл нь шаварт шигтгэхийг чөтгөр ч таахын аргагүй болов. Уг нь МАН энэ зэргийн юмыг сэгсэрвэл сэгсрээд босоод ирэхээр том нам. Гэвч тэжээсэн “бяруу”-нуудаа тэргээ эвдүүлээд дуусах хувь тохиол хүлээж буй бололтой. Жинхэнээсээ энэ намыг цэвэрлэх цаг болсон байна. Хоёр гишүүнгүй байлаа гээд яадаг юм, АН-ыг мөхөөсөн эрүүл бус сөргөлдөөн МАН-ыг бүү мөхөөгөөсэй...


Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

# НИЙГЭМ

Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## “Оюутны сургалтын тэтгэлэг”-ийг 25 хүн авна

Аймгийн Засаг даргын нэрэмжит “Оюутны сургалтын тэтгэлэг” авах иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг хуралдаж, тэтгэлэг авах болзлыг хангасан иргэдийг сонгон шалгаруулжээ. Энэ онд нийт 45 иргэн материалаа бүрдүүлж ирүүлсэн байна. Үүнээс энэ жил ЕБС-иа төгсөөд их, дээд сургуульд элсэн орсон 33 хүүхэд, хоёр болон түүнээс дээш курсын 12 оюутан байжээ. Журамд заасан болзлын дагуу хагас болон бүтэн өнчин эсэх, амьжиргааны орлого багатай, сурлагын голч дүн зэрэг үзүүлэлтийг хэлэлцжээ.

Энэ онд аймгийн Засаг даргын нэрэмжит “Оюутны сургалтын тэтгэлэг”-ийг хагас болон бүтэн өнчин 10, ажилгүй, хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон эмэгтэй, амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрхийн 15, нийт 25 оюутанд олгохоор шийдвэрлэсэн байна. Тэтгэлэгт тэнцсэн иргэдэд аймгийн Засаг даргын “Батламж”-ийг аймгийн Засаг дарга Г.Батсуурь, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг нар гардуулжээ.

ОРХОН АЙМАГ

## Иргэд “Хотын статустай” болох санал гаргав

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаархи уулзалт, хэлэлцүүлэг Орхон аймагт хоёр өдөр үргэлжилжээ. Уулзалт, хэлэлцүүлгийг УИХ-ын Тамгын газрын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Ц.Батбаатар удирдаж, Баян-Өндөр, Жаргалант сумын иргэдтэй уулзаж санал бодлыг нь сонссон байна. Уулзалтын үеэр иргэд, Орхон аймгийг “Хотын статустай” болгох нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлжээ. Тодруулбал, Баян-Өндөр сум хүн амын төвлөрөл ихтэй, үйлдвэр, аж ахуйн томоохон бүс хэрнээ газар нутаг багатайгаасаа болж Булган аймагтай үл ойлголцох, иргэд ч Үндсэн хуулиар олгосон эрхээ бүрэн эдэлж чадахгүй байгаа аж. Тухайлбал, талийгаачаа оршуулах газаргүй байгаа гэнэ. Иймд Орхон аймаг “хот” болбол багууд нь хороо болж нутгийн захиргааны байгууллагуудын бие даасан байдал, чадвар чансаа сайжирч, төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ гэж иргэд онцолжээ. Мөн сонгуульд оролцох иргэдийн оролцооны асуудал, энэ талаар хатуу зохицуулалт байж болох эсэх, УИХ–аар хууль эцэслэн баталж буй босгыг өөрчлөх, давхар дээлийн асуудал яригдаж байхад “гуравны нэг” гэдэг тоог заавал оруулах шаардлага байгаа эсэх, хуульд нэмэлт өөрчлөлт орууллаа гэхэд хэрэгжих хугацааг наашлуулж болох эсэхийг ч асуужээ. Энэ үеэр АИХ-ын депутат байсан Д.Цэен-Ойдов УИХ-ын олон гишүүн давхар дээлтэй байгаагаас төр, засаг тогтворгүй байгааг шүүмжилж, Ерөнхий сайд, Шадар сайд хоёроос бусад нь УИХ-ын гишүүн байх ёсгүй гэсэн саналтай байгаагаа илэрхийлжээ. Харин зарим иргэн багийн Засаг дарга болон УИХ-ын гишүүнээр томилогдох насны хязгаарыг нэмэгдүүлэх, Төрийн сүлд, Төрийн дууллыг дахин өөрчлөх, бүх шатны байгууллагуудын сонгуулийг нэг дор явуулах, УИХ-ын гишүүдийн бүрэн эрхийг таван жил болгон сунгах, Үндсэн хууль дахь нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжиж эхлэх хугацааг 2020 оноос наашт татах зэрэг олон санал дэвшүүлсэн байна.

ДОРНОГОВЬ АЙМАГ



## Аймгийн ШШГА-ны 15 жилийн ой тохиолоо

Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 15 жилийн ойн баяр тохиожээ. Ойн баярын жагсаал, хүндэтгэлийн хуралд Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Ганзориг нар оролцож Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байгаа офицер, ахлагч, шийдвэр гүйцэтгэгч, нийт албан хаагчид, үе үеийн ахмад хөдөлмөрчдөд баяр хүргэж шагнал гардуулжээ.

Тус аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын Дорноговь аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу тус албаны шуурхай байдлыг хангахад зориулж харуул хамгаалалтын гэрэлтүүлэг, камер суурилуулахад 3.2 сая, бусад албаны үйл ажиллагаатай танилцах, сайн туршлагыг судлахад 306 мянга, суудлын автомашин авахад 13 сая төгрөгийг тус тус шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа аж. Автомашиныг ойн баярын хурлын үеэр гардуулан өгчээ. Мөн Дорноговь аймгийн ИТХ, Сайншанд сумын ЗДТГ болон хамтран ажилладаг бусад байгууллагуудын зүгээс Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдад шагнал гардуулсан байна.

## “Сайншанд салхин парк”-ийн санхүүжилтийг шийджээ

Сайншанд дахь 55 мегаваттын чадалтай салхин цахилгаан станц хөрөнгө оруулагчдаас 120 сая ам.долларын санхүүжилтийг хүлээн авахаар болжээ. Энэхүү төсөл нь Монголд хэрэгжиж буй гадаадын хөрөнгө оруулалттай гурав дахь төсөл бөгөөд ногоон эдийн засгийг дэмжих зорилготой юм. Төслийг хэрэгжүүлэгч “Сайншанд салхин парк” компани хөрөнгө оруулалтаа Францын эрчим хүчний “Engie”, Германы “Ferrostal” компаниудаас гадна Данийн уур амьсгалын өөрчлөлтийн хөрөнгө оруулалтын сан болон Үүсгэн байгуулагч Р.Даваанямын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй юм байна. Харин санхүүжилтийн зарим хэсгийг Еропын хөрөнгө оруулалтын банк, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас авахаар болжээ.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр ойролцоогоор 130 гаруй мянган айл өрхийн цахилгааны хэрэглээг хангах ногоон эрчим хүч үйлдвэрлэж, 200 мянга гаруй тонн нүүрс хүчлийн хий агаар мандалд ялгарахаас сэргийлэх аж. Ингэснээр нүүрс хүчлийн ялгаруулалт буурахын зэрэгцээ 2030 онд нийт эрчим хүчний 30 хувийг сэргээгдэх эрчим хүчээр бүрдүүлэх зорилтод хүрэхэд дөхөм болж байгаа юм.

Харин станцад ашиглах үндсэн тоноглолд Дани улсын “Vestas” фирмийн нэгж бүр нь хоёр мегаваттын чадалтай 26 ширхэг салхин турбин ашиглахаар болжээ. “Сайншанд салхин парк” компанийн мэдээлснээр станцын барилга угсралтын ажил энэ онд эхэлсэн. Мөн улсын комисст 2018 оны хоёрдугаар хагаст хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

СУДЛААЧ ЯРЬЖ БАЙНА

# Ж.Батсуурь: Тодорхой хэмжээнд цус ойртоогүй аймаг, сум гэж байхгүй болсон



Г.ГАНЧИМЭГ

*Шинжлэх ухааны доктор профессор, хүн судлаач Ж.Батсуурьтай угийн бичиг хөтлөхийн ач холбогдлын талаар ярилцлаа.*

**-Өнөөдөр монголчууд угийн бичиг хөтлөхөд нэг их ач холбогдол өгөхгүй байх шиг байна. Үүний нэг тод жишээ нь бараг бүгдээрээ шахам Боржигон овогтой болчихсон. Тэгээд түүнийгээ хэдэн янзаар бичнэ. Үнэхээр өөрийнх нь уг үндэс мөн үү гээд судлахаар биш байх жишээтэй?**

-Монголчууд өргөн уудам нутагт их цөөхүүлээ амьдарч ирсэн түүхтэй. Аливаа ард түмний хувьд хамгийн үнэт зүйл нь төрөлх газар шороо, хоёрдугаарт удмын сан, гуравдугаарт уламжлалт соёл байдаг юм. Тиймээс улс гүрэн өөрийнхөө хөгжлийн асуудалд цогц хандахыг хичээдэг. Ингэхдээ хүн амынхаа удмын санг ямагт цэвэр ариун, үргэлж тунгалаг байлгахыг зорьдог юм. Өөрөөр хэлбэл, ямар ч нөхцөлд сэргэлэн цовоо, саруул ухаантай, сайхан бие бялдартай үр удам төрүүлэхийн төлөө л тэмцдэг. Ер нь аливаа амьд амьтан, хүн удмын сандаа цус ойртсон шинж тэмдэг илрэхээс зайлсхийдэг. Ийм гайхамшигтай өв соёлыг бидний өвөг дээдэс олон зууны тэртээ бүтээжээ. Энэ өргөн уудам нутагт цөөхүүлээ амьдарч буй ард түмэн оршин тогтнохуйн эл нууцыг мэдэрч, ухаарч, гайхамшигтай өв соёлыг бүтээсэн байдаг. Гэтэл энэ гайхамшигтай өв соёлоо мартагнах гээд байдаг болжээ. Зүйрлэж хэлбэл, өнөөгийн залуус аавын талыг авга, ээжийн талыг нагац гэдгийг мэдэж байна. Гэхдээ өөрөөсөө дээш хоёр үеэ л муухан мэддэг. Сайн мэдэж байгаа нь овог нэр, төрсөн жил, амьдарч байсан газар нутаг, хэдэн хүүхэд төрүүлснийг л хэлнэ. Тэгээд түүнээс цаашаа мэдэхгүй болчихдог. Удмын сангийн мэдээлэл ингэж бүдгэрч байхгүй болохоор ирээдүйд үр удам нь хань ижлээ сонгохдоо ямар түвшинд ураг төрлийн холбоотой байж болохвэ гэдгийг мэдэх аргагүй болчихдог юм. Үүнээс болгоомжилж есөн үеэ мэддэг, есөн үе дотроо гэр бүл болдоггүй байсан гайхамшигт өв соёлыг монголчууд 800 жилийн тэртээ бий болгосон шүү дээ. Их эзэн Чингис хаан үүнийг их хатуу мөрдлөг болгож, авч явсан юм байна. Энэ тухай хүн төрөлхтөний түүхийг бичилцэж байсан тэр том эрдмийн мэргэд хүртэл гайхширч бичсэн байдаг. Ураг удам, ахан дүүсээ мэдэхгүй монгол хүн гэж байхгүй. Өөрөөсөө дээшээ есөн үеэ мэддэг ард түмэн. Ийм учраас үр удам нь хоорондоо гэрлэж, цус ойртох гэсэн ойлголт байдаггүй юм байна гэж бичжээ. Тиймээс өвөг дээдсийн гайхамшигтай энэ өв соёлыг сэргээх нь чухал асуудал юм.

**-Гэтэл өнөөдөр нүүдэлчдийн сэтгэхүй өөр болчихсон, зарим аав ээж үр хүүхдээ “Нутгийнхаа хүнтэй л суугаарай. Хүний нутгийн бурхнаас өөрийн нутгийн чөтгөр дээр шүү” эсвэл “Миний хүү голоосоо л хань ижлээ сонгоорой. Хараа бараандаа амар шүү дээ” гэх маягтай, ер нь үр хүүхдээ хол нутгийн айлд өгөх дургүй, аль болох ойр байлгах сонирхолтой болжээ?**

-Энэ чинь манай нүүдэлчдийн сэтгэхүй биш. Монгол хүн угийн бичгээ хөтлөхгүй байх, овгоо халах Засгийн газрын тогтоол 1925 онд гарсан. Үүнийг монголчууд өөрсдөө гаргаагүй. Өөрсдийнхөө гараар өөрсдийгөө устгах ийм зүйл хийхгүй нь мэдээж. Хүн төрөлхтөний түүхийн тавцанд монголчууд эрэмгий зоригтой, ухаантай, бүхнээс дээгүүр соёл иргэншилтэй, оюунлаг, цөөхүүлээ хэр нь морин дэл дээрээс дэлхийг талыг эзэлж, гүрэн байгуулж явсан ард түмэн. Нэгэн үе монголчуудыг их муу хэлж, яргачин, дээрэмчин, тонуулчин, хүн төрөлхтөний соёл иргэншлийг сүйтгэсэн гээд л байсан. Одоо болсон чинь үгүй юм байна шүү, энэ монголчууд чинь хүн төрөлхтөний түүхэнд энх амгалангийн гүрэн байгуулах тэр гайхамшгийг нээж өгсөн юм байна гээд түүхийг ойлгож эхэлж байна шүү дээ. Тиймээс муу хэлж байсан тэр үедээ “Энэ монголчуудыг хүн төрөлхтөний түүхийн тавцанд ахиад гаргачихгүй юмсан” гэж болгоомжилсон байдаг. Тиймээс чимээгүйхэн шиг цаагуураа өв соёлыг нь мартагнуулаад өөрөөр нь өөрийг нь устгуулах улс төрийн үйл ажиллагаа явагдсан юм болов уу гэж бид төсөөлдөг. Өнөөдөр бид жалга довны үзэлтэй, нутгийн хүнтэйгээ гэр бүл болохыг илүүд үзэж, хараа бараатай явахыг чухалчилдаг болсон нь өв соёлыг мартагнуулсны гай. Аав ээж нь үр хүүхэддээ “Миний хүү, чи битгий нутаг усныхаа хараа барааны хүнтэй гэрлэчихээрэй дээ” гэж хэлж сургадаг байсан шүү дээ. Гэтэл одоо ойрхноос хараа бараандаа гэр бүл болж болдог юм байна гэдэг ойлголттой болчихжээ. Нөгөөтэйгүүр, Монгол нутаг их өргөн уудам. Гэхдээ өвөг дээдсийн түүхээс харахад засаг захиргааны хувьд ердөө дөрвөн аймагт л хуваагддаг байсан. Хангайгаасаа говь руу очдог, говиосоо тал хээрээр дамжаад хангайдаа ордог. Малаа сайхан оторлож таргалуулаад, нүүдэл бэлчээрээ сэлгэн байгалиа хамгаалж, хайрладаг байжээ. Ингэж явахдаа хол нутгийн залуус хоорондоо танилцаж ижилсэн гэр бүл болдог. Гэтэл одоо энэ дөрвөн аймгийг 21 аймаг 331 сум 1700 шахам баг болгон хуваачихсан. Ингээд газар нутгийг зөгийний үүр шиг болгоод хуваачихаар засаг захиргааны хувьд өөр аймаг, сум болсон залуус хоорондоо танилцаж гэрлэдэг. Энэ нь явсаар байгаад цаагуураа цус ойртолтын аюулыг чимээгүй бий болгож байна.

> ...Монгол Улсын тэдэн хувь нь тэглээ, ингэлээ гэж тодорхойлж болдоггүй үзэгдэл чинь энэ. Цус ойртолт гэдэг бол нуурын ёроолд давсны тунадас хуримтлагдаад жил ирэх тусам бага багаар нэмэгдээд байдаг шиг чимээгүйхэн яваад л байдаг өвөрмөц үзэгдэл. Өнөөдөр хүн амын доторх цус ойртолтыг тодорхойлбол тодорхой төвшинд цус ойртоогүй аймаг, сум гэж байхгүй болсон...

**-Манай улсын хүн амын хэдэн хувь нь цус ойртчихсон байна вэ?**

-Монгол Улсын тэдэн хувь нь тэглээ, ингэлээ гэж тодорхойлж болдоггүй үзэгдэл чинь энэ. Цус ойртолт гэдэг бол нуурын ёроолд давсны тунадас хуримтлагдаад жил ирэх тусам бага багаар нэмэгдээд байдаг шиг чимээгүйхэн яваад л байдаг өвөрмөц үзэгдэл. Өнөөдөр хүн амын доторх цус ойртолтыг тодорхойлбол тодорхой төвшинд цус ойртоогүй аймаг, сум гэж байхгүй болсон. Тиймээс бид өнөөдөр үр хүүхдээ сум дотроо битгий гэрлээрэй гэж хэлэхээс өөр аргагүй болчихоод байна. Үүнийг монголчууд дотроо ярих асуудал. Түүнээс биш гадаадынханд өгөөш болгох зүйл биш. Нууцын зэрэглэлтэй байх ёстой асуудал юм. Өнөөдөр манай улсын хүн амын өвчин эсэргүүцэх, үхэл даах чадвар эрс буурсан. 1990-ээд оны эхээр чихрийн шижин, хорт хавдартай хүн өдрийн од шиг цөөн байсан шүү дээ. Гэтэл өнөөдөр хорт хавдраар хоёр сартайгаас эхлээд өндөр настай гээд бүх насны хүмүүс өвчилж байна. Энэ нь нэг талдаа даяаршлын нөлөөгөөр импортоор есөн шидийн хүнс оруулж ирээд идэж байгаатай холбоотой ч нөгөөтэйгүүр өв соёлоо мартсанаас улбаатай. Цаагуураа цус ойртох үзэгдэлд нэлээд орчихсон ард түмэн чинь зохисгүй хүнсний хэрэглээний улмаас янз бүрийн өвчтэй болж хэврэгшээд яваад байна шүү дээ.

**-Ер нь дэлхийн түүхэнд хүн ам нь цус ойртоод ноцтой байдалд орж байсан жишээ байна уу?**

-Байлгүй яах вэ. Ийм нөхцөлд тухайн улс хууль гаргаад, хүн амаа хөдөлгөөнд оруулдаг. Тухайлбал, зам харгүй тавьж өгөн залуусыг хооронд нь уулзах сайхан боломжоор хангаж байсан. Цус ойртохоор хүн амын оюуны чадавхи буурч, оюуны хомсдолтой хүүхдийн тоо өсдөг. Ингэхээр шинжлэх ухаан, техникийн гайхамшгийг бүтээх чадвар буурах нь ойлгомжтой. Тиймээс хүн амаа цус ойртоогүй байсан ч ойртохоос сэргийлж, ийм үзэгдэлд оруулчихгүй байхыг төрийн хар хайрцагны бодлогоороо авч явах ёстой. Аливаа ард түмний дунд цус ойртох үзэгдэл бий болох л юм бол төрөл бүрийн өвчтэй, оюуны хомсдолтой хүүхэд төрдөг нь хууль. Герман, Япон, Орос, Монгол ялгаагүй бүгд адилхан шүү дээ. Гагцхүү тэр ард түмний дунд цус ойртох хүчин зүйлийг бий болгож буй зүйлийг арилгаж, үндэсний аюулгүй байдлын бодлогоороо хамгаалж явах ёстой.

**-Цусаа сэлгэж байна гээд гадаадын иргэнтэй гэр бүл болж байгаа монголчууд ч бий. Зарим нь үүнд их дургүйцдэг. Эрлийз, хурлийз хүүхэд төрүүлж цусаа бохирдууллаа гэдэг шүү дээ?**

-Гадаадын иргэнтэй гэр бүл болох нь замбараагүй болбол цөөхүүлээ үндэстэн бүр хайлаад алга болно шүү дээ. Тиймээс харийнхантай хэт их ойртож, хэтэрхий олноороо гэр бүл болж болохгүй.

**-Гадаадын зарим кинон дээр хааны угсааныхан үеэлтэйгээ сууж байгаа тухай гардаг. Үүнийг залуу үеийнхэн, хүүхдүүд яагаад гэж их асуудаг шүү дээ?**

-Хүн төрөлхтөний генетикийн сургамжууд бий. Хаан угсааны цус харц хүний цустай холилдох ёсгүй гээд дээдсийн хүрээндээ үржиж өсч байх ёстой гэдэг үзэл баримтлал түүхийн явцад байсан уу гэвэл байсан. Үүнтэй холбоотойгоор хоорондоо гэрлэсээр байгаад хаан угсаа устаж, бүхэл бүтэн овог аймаг мөхсөн нь ч бий. Ийм жишээ олон. Эмэгтэйчүүдээ хамгаалаагүй үндэстэн мөхдөг, эрчүүдээ дээдлээгүй улс сөхөрдөг гэж мэргэдийн үг бий. Хүний генетикийн шинжлэх ухаан хөгжиж ирсэн цагаас л үүнийг мэддэг болсон шүү дээ. Ер нь генетикийн шинжлэх ухаан чинь 1900 оноос л хөгжиж эхэлсэн юм. Гэтэл монголчууд генетикийн хуульгүй, энэ шинжлэх ухаан үүсээгүй байхад буюу 800 жилийн тэртээгээс хүний удамшлын шинж тэмдэг яаж өвлөгдөж ирдэг вэ гэдгийг мэдэж байсан. Тэр байтугай малын удмын санг хамгаалж эцэг малыг холоос авчирч тавьдаг уламжлалтай шүү дээ. Хүн уламжлалт соёлоо гээвэл араатан л болдог. Юуг ч устгаж, юуг ч барьж идэж чадна. Хүнийг хазаарлаж барьдаг зүйл чинь уламжлалт соёл шүү дээ. Үүнийгээ дээдэлж байж бид бүтэн Монгол болно.

ОНЦЛОХ ХУУДАС

# ХЭНД НЬ ИТГЭХ ВЭ

## Эсрэг тэсрэг байр суурь

### Э.Идэрцог: У.Хүрэлсүх өөрийгөө мөшгиж, мөрдүүлсэн нь тогтоогдсон



*/АТГ-ын Мөрдөн байцаах хэлтсийн дарга, Эрхэлсэн комиссар/*

...Өнөөдрийн байдлаар уг хэрэгт тогтоогдсон зүйл гэвэл, Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх 2017 оны долдугаар сард төрсөн дүү У.Отгонбаяр болон өөрийн хамаарал бүхий хүмүүсээр дамжуулан өөрийгөө мөрдөн мөшгисөн гэх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан. Энэ хэрэгт яллагдагчаар татах асуудлыг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн...

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дугаар зүйлд заасны дагуу хэрэг бүртгэл мөрдөн байцаалтад байгаа хэргийг прокурорын зөвшөөрөлтэй нийтэд мэдээлэх ёстой. Тийм учраас та бүхэнд өгөх миний мэдээлэл хязгаарлагдмал байна гэдгийг ойлгох хэрэгтэй. Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийг мөрдсөн гэх хэрэг ТЕГ, ЦЕГ-аар дамжин 2017 оны наймдугаар сарын 7-ны өдөр АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст ирж, шалгагдаж байгаа. Уг хэрэгт нийт есөн хүнийг холбогдуулан шалгаж байна. Мөрдөн байцаалтын ажиллагаанд мөрдөн байцаагч прокурорт саналаа хүргүүлсний дараа прокурор шийдвэр гаргадаг. Үүний дараа мөрдөн байцаалтын ажиллагаа явагддаг гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өнөөдрийн байдлаар уг хэрэгт тогтоогдсон зүйл гэвэл, Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх 2017 оны долдугаар сард төрсөн дүү У.Отгонбаяр болон өөрийн хамаарал бүхий хүмүүсээр дамжуулан өөрийгөө мөрдөн мөшгисөн гэх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан. Энэ хэрэгт яллагдагчаар татах асуудлыг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн. Хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа хэвийн үргэлжилж байна. Уг хэргийн захиалагч нь хэн бэ, Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат оролцсон гэдэг нь тогтоогдоогүй байгаа.

### А.Үйлстөгөлдөр: АТГ бодит үнэнийг мушгин гуйвуулсан учраас цаашид зүгээр суухгүй



*/Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн хэвлэлийн төлөөлөгч/*

...Шадар сайд У.Хүрэлсүх удаа дараа хуулийн байгууллагад гомдол, хүсэлт гаргасан ч ТЕГ, АТГ хоёр сар гаруйн хугацаанд энэ хэргийг үнэн зөв шийдэх талаар дорвитой ямар ч алхам хийгээгүй атлаа өнөөдөр иим мэдээлэл хийж байгаа нь илтэд нэг талыг барьсан улс төрийн зорилготой, бодит үнэнийг мушгин гуйвуулсан үйлдэл боллоо гэж үзэж байна...

-Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн эрүүл мэнд, нэр төр, аюулгүй байдалд халдахаар Монгол Улсын зарим иргэд хууль бусаар тагнах, чагнах, мөрдөх ажиллагаа явуулж байгаа мэдээллийг шалгуулах талаар Шадар сайдын ажлын албанаас 2017 оны долдугаар сарын 3-ны өдөр Тагнуулын Ерөнхий газар болон Авлигатай тэмцэх газарт хүсэлт гаргасан. Мөн 2017 оны долдугаар сарын 31-ний өдөр Үндсэн хуулийн 42 дугаар зүйл, УИХ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.3, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.3.1-д заасныг үндэслэн УИХ-ын Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд хүсэлт хүргүүлсэн. Гэвч АТГ-аас наймдугаар сарын 25-ны өдөр хэвлэлийн бага хурал хийх үеэр Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх 2017 оны долдугаар сард өөрийн төрсөн дүү У.Отгонбаяр болон хамаарал бүхий хамаатны хүмүүсээрээ дамжуулан өөрийгөө мөрдөн мөшгисөн учир яллагдагчаар татах саналыг нийслэлийн Прокурорын газарт хүргүүлчихсэн, хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжлээд явж байна гэсэн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацлаа. Шадар сайд У.Хүрэлсүх удаа дараа хуулийн байгууллагад гомдол, хүсэлт гаргасан ч ТЕГ, АТГ хоёр сар гаруйн хугацаанд энэ хэргийг үнэн зөв шийдэх талаар дорвитой ямар ч алхам хийгээгүй атлаа өнөөдөр иим мэдээлэл хийж байгаа нь илтэд нэг талыг барьсан улс төрийн зорилготой, бодит үнэнийг мушгин гуйвуулсан үйлдэл боллоо гэж үзэж байна. Хэргийн гэрч, оролцогч болох иргэн Ч.Батболд болон холбогдох гэрчийн этгээдүүд хууль хяналтын байгууллагад хандан бодит үнэнийг хүлээн зөвшөөрч, нотолсоор байтал хууль хяналтын байгууллага бодит үнэнийг олон нийтэд мэдээлсэнгүй. АТГ болон ТЕГ-ын холбогдох албан тушаалтнуудын гаргаж буй энэхүү үйлдэл нь зарим төрийн өндөр дээд албан тушаалтан хүссэн үедээ Улс төрийн зорилгоор хууль хүчний байгууллагыг өөрийн эрх ашигт үйлчлүүлж байгаагийн тод жишээ болж байна. Удахгүй Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх болон түүний өмгөөлөгч нар бодит байдлыг олон нийтэд мэдээлэх болно”.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### “ТУЛААН” УЛАМ ШИРҮҮСЛЭЭ

Н.БОЛД

УИХ-д үнэмлэхүй олонхи болж, ямар ч шийдвэрийг дангаар гаргаж чадахаар болсон МАН-ынхан ажлаа эхэлснээс хойш жилийн дараа л хоорондоо маргалдаж, мэтгэлцэж эхэллээ. Тэр ч битгий хэл анх удаагаа Засгийн газраа өөрсдөө унагахаар бичиг сачиг өгөлцөж, авалцлаа. Нэгэнт л Засгийн газрыг унагахаар, Ерөнхий сайдыг огцруулахаар гарын үсэг цуглуулаад, УИХ-д өргөн барьчихсан бол асуудлыг хэлэлцэх л ёстой болж байгаа юм. Зарим нэг нь УИХ-ын дарга эзгүй байхад дэд даргад өгсөн нь буруу л гээд байгаа. Нөгөө хэсэг нь МАН-ын болон УИХ-ын дарга зугтаасан гэж ч бичиж, яриад байна. Аль нь ч байлаа гэсэн МАН-ын хагарал хурцадсан нь үнэн. Хурцдах битгий хэл хоёр талын нэг нь “будаа” болж байж л дуусах шинжтэй байна. Ингэж хурцдах дээрээ тулсан шалтгаан нь Шадар сайдыг тагнаж, чагнасан гэх хэрэг. Дээрээс нь 60 тэрбумын асуудал ч бас байгаа. Хоёр тал асуудлыг өөр өөрсдийнхөө өнцгөөр тайлбарлаж байна. Засгийг унагаж, намын дарга, цаашлаад Ерөнхий сайдын эрх мэдлийг авахаар зүтгэж байгаа тал нь бүх зүйлийг муу муухайгаар л ярьж таарна. Угаасаа ч тэгсэн. Зарим нь намын эв нэгдлээр хаацайлж шударга бус үйлдлүүдийг өөхшүүлж болохгүй гэж ярьсан байна билээ. Буруу гэх арга байхгүй. Харин нөгөө талаас эрх мэдэлд хэтэрхий улайрагсад Засгийн газраар тоглох гэж байна. Засгийн газар унаж, Ерөнхий сайд огцорлоо гээд сайн юм болохгүй. Тэд эрх мэдлийн төлөө улайрахдаа юу ч гэж ярьж магадгүй гээд буй. Бас л буруутгах аргагүй юм. Тэгвэл хоёр талын энэ маргаан дээр тос асгасан мэдэгдлийг өнгөрсөн баасан гарагт АТГ хийчихлээ. Тэр нь Шадар сайд өөрийгөө тагнаж, чагнасан явдал. Тэр ажиллагааг өөрөө зохион байгуулсан нь тогтоогдсон. Тэгэхдээ тагнуулд ажилладаг төрсөн дүүгээ ашигласан. Тиймээс яллагдагчаар татлаа гэсэн мэдээлэл. Шадар сайдыг тагнасан, араас нь дагасан гэх хэргийн гэрч гээд байсан залуучуудыг саатуулан шалгаж байгаа. Зарим нь ч гадуур байцаагдаж байгаа гэх. Бас утасны яриаг чагнасан гэх асуудал бий. Тэр бүхнийг мань эр өөрөө зохион байгуулсан болчихлоо. Эсрэг талаас дорвитойхон хөдөлж эхэллээ. Харин АТГ-ын хурлын араас Шадар сайдын ажлын албанаас мэдээлэл хийсэн. Улмаар АТГ, ТЕГ-т Шадар сайд гомдол гаргаад, сар гаруйн хугацаа өнгөрчихөөд байхад огт хөдлөөгүй. Тэгсэн одоо иим мэдээлэл хийж байгаа нь хэт нэг талыг барьсан, бодит үнэнийг мушгин гуйвуулсан гэж үзэж байгаагаа тэд хэлсэн. Цаашлаад бодит үнэнийг мэдээлнэ гэдгээ ч хэллээ. Асуудал улам л хурцдах нь. Одоогоор энэ хэрэг баттай нотлогдоогүй, асуудал цаашид улам хурцдаж, сунжрах нь тодорхой байна. Тийм болохоор тэрнийх нь зөв, түүний буруу гэж хэлэхэд эрт. Харин нэг л үнэн юм байгаа. Тэр нь улс орны байдал дээрдэхгүй л байна. Энэ зун ган болчихлоо. Хадлан тариа, төмс ногоо олигтой ургасангүй. Ирэх өвөл хүйтэрч, зуд болох магадлал ч их байна. Улс оронд хийх ажил, тулгамдсан асуудал дүүрэн байгаа. 2018 он гараад дарах баахан өр хүлээсээр. Бидний өмнөөс хэн ч асуудлыг шийдэхгүй. Иим үед эрх баригчид нь хагаралдаад, “уралцаад” байх нь ард түмэнд ашиггүй л байх. Тэр дундаа Засгийн газар унавал тийм ч сайхангүй болов уу. Дахиад Засгийн газар байгуулах гэж хэр удах билээ. Шинээр гарч ирсэн хүмүүс нь улс орныг сэв хийтэл өргөөд, өөд нь татаад, өр ширийг нь дараад, зөв бодлого бариад явна гэхэд хэцүү л байна. Тийм болохоор энэ том нам ирэх сард болох хурлуудаараа асуудлаа шийдээд, нэг талдаа гараад, улс орноо бодоосой билээ л гэж залбирахаас. Өөр яалтай ч билээ. Одоо бол нэг л зүйл тодорхой байна. “Тулаан” улам ширүүсчихлээ.

## ДЭЛХИЙ

# ПХЕНЬЯН “ЦАГААН ТУГ” ӨРГӨВ ҮҮ



Б.ДАВАА

Хойд Солонгос улс Япон тэнгисийн зүг гурван пуужин харвасны нэг нь хөөрөөд удаагүй байхдаа дэлбэрч, үлдсэн хоёр нь 250 км зам туулсан гэх мэдээлэл гарсан. Тэдгээр гурван пуужинг Ганвон аймгаас хөөргөжээ. Хойд Солонгос тив алгасагч баллистик пуужингийн туршилт хийсэнтэй холбоотойгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөл энэ сарын 5-ны өдрийн хуралдаанаар АНУ-ын талаас тавьсан саналыг хэлэлцэж, нийт гишүүдийн 100 хувийн саналаар Пхеньяны эсрэг авах хориг арга хэмжээгээ чангатгахаар шийдвэрлэсэн юм. Энэ шийдвэрийн хүрээнд НҮБ-ын гишүүн орнууд Хойд Солонгосын нүүрс, төмөр, төмрийн хүдэр, хар тугалга зэрэг ашигт малтмалын импортдоо цэг тавьж, тус улсын гадаад худалдааны банкны дансыг царцааж, тэнгисийн цэргийн хөлөг онгоцыг нь бүх улсын боомт руу орохыг хориглосон. Үүний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Пхеньяныг сүрдүүлсэн мэдэгдэл хийснээр Ким Жон Ун Гуамын арал руу пуужин харвах цэргийн стратеги боловсруулж эхэлсэн гэдгээ мэдэгдсэн удаатай. Мөн БНСУ, АНУ-ын жил бүр болдог хамтарсан цэргийн сургуулилт Солонгосын хойгт эхэлж, эдүгээ ид дундаа өрнөж буй. Гэхдээ хоёр талын аль аль нь хэн нэгэн нь түрүүлж, өдөөн хатгасан үйл ажиллагаа явуулах тэр үед дайн эхэлнэ гэж мэдэгдсэний дараа нөхцөл байдал намжсан.

Харин энэ үед Пхеньян дахин гурван нисдэг биетийг хөөргөн туршилт хийснээр байдал хурцдах вий гэсэн болгоомжлол бүс нутагт үүсээд байв.

Тэгвэл энэ удаад Пхеньян нисдэг биетээ Гуам, эсвэл АНУ-ын эзэмшлийн аль нэг нутаг дэвсгэр рүү чиглүүлсэнгүй. Үүнийг АНУ-ын Номхон далайн командлал ч баталсан юм. Түүнчлэн, БНСУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Пхеньяны харвасан нисдэг биетийн талаар мэдэгдэл хийж, пуужин биш байсан гэдгийг тодотгожээ. Тэд “Их буу, баллистик пуужин, тив алгасагч пуужин аль нь ч биш байсан. Цэргийн сургуулилтынх нь нэг хэсэг байсан гэж үзэж байна” хэмээсний зэрэгцээ өдөөн хатгасан үйл ажиллагаа биш гэдгийг мөн хүлээн зөвшөөрчээ.

Харин “Франц пресс” агентлагийн сэтгүүлчийн тэмдэглэснээр энэ удаагийн Пхеньяны үйл ажиллагаа өдөөн хатгалгаас зайлсхийж, хэлэлцээрийн ширээний ард суух сонирхол байгааг нь илтгэсэн явдал боллоо гэж дүгнэн бичсэн байна.

БНСУ-ын Хөх ордны төлөөлөгч хэвлэлийн бага хурлын үеэр “Богино зайн нисдэг биет байсан. БНСУ-АНУ-ын хамтарсан цэргийн сургуулилт ид дундаа өрнөж буй энэ үед биш, өөр тохиолдолд бол Үндэсний аюулгүй байдлын байнгын хорооны төвшинд ярих шаардлагагүй. Япон ч гэсэн Үндэсний аюулгүй байдлын хороогоо хуралдуулахаас татгалзсан” гэж ярьжээ.

Харин тус нисдэг биет чухам юу байсан талаар сэтгүүлчид түүнээс лавлаж асуухад “Хойд Солонгос ямар нисдэг биет харвасныг нь тогтооход хэдэн өдөр, цаг шаардлагатай байх. БНСУ-АНУ-ын тал хамтран хэлэлцсэний үндсэн дээр нэг үр дүн гарах байх” гэсэн байна.

Өнгөрсөн долоо хоногт Вашингтон Хойд Солонгостой харилцах харилцаанд нааштай өөрчлөлтүүд гарч байгааг мэдэгдэж байв. Тухайлбал АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рэкс Тиллерсон “Пхеньяны дэглэм өмнө нь үзэгдэж байгаагүйгээр асуудалд тэвчээртэй хандаж эхэлснийг мэдэгдэхэд таатай байна” хэмээж, ойрын өдрүүдэд талууд хэлэлцээрийн ширээний ард сууж магадгүй гэж мэдэгдсэн.

Мөн АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Ким Жон Уныг АНУ-д хүндэтгэлтэй хандаж эхэлснийг онцолж, “Зарим эерэг дүн гарах байх” гэсэн хүлээлттэй байгаагаа илэрхийлж байлаа. Нөгөөтэйгүүр, Пхеньяны цэргийн командлагч Ким Жон Ун улсдаа цэргийн сургуулилт зохион байгуулсан гэх мэдээлэл бий. Тиймээс, тус харвасан нисдэг биет энэ удаагийн сургуулилтынх нь нэг хэсэг байсан байх магадлалтай гэдгийг БНСУ, АНУ-ын тал ч мэдэгдэж байгаа юм.

Ямартай ч, АНУ болоод БНСУ-ын талын дээрх мэдэгдэл болон шахалтууд үр дүнгээ өгвөл Пхеньян “Цагаан тугаа” өргөж, хэлэлцээрийн ширээний ард сууж магадгүй нь.

### Брюссельд зэвсэгт халдлага гарлаа

Бельгийн нийслэл Брюссель хотын төв хэсэгт хутгаар зэвсэглэсэн эрэгтэй цэргийнхэн рүү халдаж, нэг хүнийг шархдуулжээ. Үүний дараа хэт даврагч “Лалын улс” бүлэглэлээс мэдэгдэл хийж, хутгаар зэвсэглэсэн этгээд тус бүлэглэлийн дайчин байсныг олон нийтэд мэдээлсэн байна.

Халдлага энэ сарын 25-нд гарчээ. Зэвсэгт этгээд эхлээд цэргийнхэн рүү дайрч, нэг цэргийг хөнгөн шархдуулахад нь бусад нь гэмт этгээдийг буудан хөнөөжээ. Уг хэргийн талаар албаны эх сурвалж “Террорист халдлага” гэж үзэж буйгаа мэдэгдсэн бол хотын захирагч Филипп Клөүс “Ганц хүний үйлдсэн гэмт хэрэг” гэж ярьжээ.

Брюссельд болсон уг халдлагаас хэдэн цагийн дараа Их Британийн нийслэл Лондон хотод ч гэсэн Букингем ордны өмнө зогсч байсан гурван цагдаа руу 1.2 метрийн урт балиусаар зэвсэглэсэн этгээд халдаж шархдуулсан хэрэг гарсан байна. Гэмт этгээдийг цагдаа нар саатуулжээ.

Дашрамд дуулгахад, Европод хоёр жил орчмын өмнөөс террорист халдлагууд гарах болсон юм. Энэ сарын 17-нд гэхэд Испанид машинаар явган зорчигчдыг дайрсан халдлага гарч, 15 хүн нас барсан бол түүнээс нэг хоногийн дараа Финляндад мөн ижил хэрэг гарч, гэм зэмгүй хоёр иргэн амиа алдсан билээ.

### Ийнглак Чинават гадаад руу зугтжээ

Тайландын экс Ерөнхий сайд 50 настай Ийнглак Чинават өнгөрөгч долоо хоногийн баасан гарагт болсон шүүх хуралд оролцоогүй. Үүнтэй холбоотойгоор тус улсын дээд шүүх түүнийг баривчлан, саатуулах шийдвэр гаргасан юм.

Шүүгчид түүнийг хэрэгт холбогдон шалгагдаж байх хугацаандаа оргон зайлж болзошгүй гэж үзсэн байдаг. Тэгвэл Ийнглак аль хэдийнэ гадаад руу оргон зайлсан нь тодорхой болжээ. Шүүх хурлын үеэр Ийнглакийн өмгөөлөгч нь түүнийг эрүүл мэндийн шалтгааны улмаас ирээгүй гэж тайлбарлажээ. Гэвч шүүгч “Шүүх бүрэлдэхүүн түүнийг эрүүл мэндийн шалтгаантай гэдэгт итгэхгүй байна. Тиймээс саатуулах шийдвэр гаргалаа” хэмээжээ. Мөн шүүх хурлыг есдүгээр сарын 27-ныг хүртэл хойшлуулсан байна. Гэвч, Ийнглакийн тэргүүлдэг “Pheu Thai” намын гишүүн түүнийг аль хэдийнэ гадаад улсад орогнож буйг нь “Франц пресс” агентлагт мэдээлжээ. Тодруулбал, “Ийнглак Тайландад байхгүй. Магадгүй одоо Сингапурт байгаа байх” гэж ярьжээ. Тус улсын цэргийн дэглэмийн удирдагч, Ерөнхий сайд Праюот Чан О’Чагийн мэдэгдсэнээр тэд Ийнглакийг эдүгээ яг хаана байгааг нь мэдэхгүй байгаа бөгөөд хилийн хяналт шалгалтаа чангатгахыг үүрэгджээ. Ийнглак Чинават хөрш Сингапураар дамжин гадны улс оронд орогнож байх магадлалтай гэнэ. Түүний ах мөн экс Ерөнхий сайд Таксин Чинават авлигын хэргээр шүүхээс хоёр жилийн ял сонссон ч, 2008 оноос хойш гадаад улсад орогнож байгаа билээ. Харин Ийнглак Чинават шүүхээр гэм буруутай нь тогтоогдвол хамгийн ихдээ чанга дэглэмтэй хорих ангид 10 жил хоригдож, улс төрд насан туршдаа орохыг нь эрхгүй болж магадгүй юм. Ингэснээр 10 гаруй жилийн турш Тайландын улс төрд нөлөөллөө хадгалж ирсэн Таксинд томоохон цохилт болно гэж ажиглагчид үзэж байна.

Ийнглак Чинават өөрийгөө “Бохир улс төрийн тоглоом”-ын хохирогч хэмээж, ямар ч буруугүй гэдгээ удаа дараа мэдэгдэж байсан юм. Түүнд тулгаж буй ял нь Засгийн газраас хөдөөгийн тосгодын цагаан будааг барьцаа хөрөнгө болгон худалдан авч, зээл олгох тогтолцоотой нь холбоотой. Тэрбээр сонгуулийн мөрийн хөтөлбөртөө эл амлалтыг тусгаж, тухайн үед нь ч дэлхийн зах зээл дэх будааны үнэ хоёр дахин нэмэгдсэнээр ялалтын түлхүүрийг түүний гэр бүл атгасан билээ. Гэвч, авлига авч, улс орноо сүйрэлд хүргэсэн гэх шалтгаанаар түүнийг буруутган, 2014 онд цэргийнхэн хүчээр төрийн эрх мэдлийг гартаа авсан юм.


*Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын засгын*
*2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн*
*53 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

## ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЫН МАЯГТ

**1. Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга**

А. Хичээлийн өргөтгөлийн байранд цайны газар (Талбайн хэмжээ: Заал 5,50 х 11,47 м, гал тогоо 5,87 х 8,70 м)

Б. Төв байранд 3,40 х 5,40 м талбай бүхий өрөөг оффис, үйлчилгээний зориулалтаар,

В. Оюутны байранд 2,82 х 4,90 м талбай бүхий 3 өрөө, мөн 2,59 х 6 м = 16 м2 талбай бүхий нэг өрөөг үйлчилгээний зориулалтаар тус тус түрээслүүлнэ.

(эд хөрөнгийг түрээслүүлэх зориулалт, түрээслүүлэх талбайн хэмжээ, хаяг байршил болон бусад шаардлагатай мэдээллийг тусгана.)

**2. Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл**

| | |
|---|---|
| Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа | 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цагт (сонгон шалгаруулалтыг зарласнаас хойш 15-аас багагүй хоногоор тогтоох) |
| Материал хүлээн авах хаяг | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Баруун дөрвөн зам, Барилгын Политехник Коллеж, 2 давхар, 202 тоот |
| Материал нээх хугацаа, хаяг байршил | 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 11 цагт (материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор, оролцогчдын өмнө нээх ) |
| Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ: | Үйлчилгээний зориулалтаар түрээслүүлэх өрөө 1 м2 нь 15,000 (арван таван мянган) төгрөг<br>Цайны газар 1 м2 нь 10,000 (арван мянган) төгрөг |
| Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл | Шаардлагагүй (шаардлагатай тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг бүрэн тусгах) |
| Түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай ерөнхий мэдээлэл | (шаардлагатай мэдээллийг тусгах) |
| Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал | • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар;<br>• Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлыг бичих);<br>• Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн, хуулийн этгээдийн харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт);<br>• Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;<br>• Шаардлагатай тохиолдолд худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг;<br>• Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал................................ (түрээслүүлэх эд хөрөнгийн нөхцөл байдал, онцлогоос хамааран түрээслүүлэгч нь нэмэлт материал шаардаж болох бөгөөд зард заавал тусгах) |

**3. Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах**

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Барилгын Политехник Коллеж дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шарлгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг Барилга политехник коллежийн 7720 0507 утсаар болон цахим хуудаснаас авна уу.

**Хаяг: Барилгын Политехник Коллеж**
**Холбогдох утасны дугаар: 99060686, 77200507**



## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД АЖИЛЛАХ ТОГООЧ, ТУСЛАХ ТОГООЧ ШАЛГАРУУЛЖ АВНА

**Тавигдах шаардлага:**
-Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологич мэргэжилтэй
-Тогоочийн зэрэгтэй байх
-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан
-Нийтийн хоолны салбарт мэргэжлээрээ 3 ба түүнээс дээш жил ажиллаж байсан туршлагатай
-Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
-Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай

**Бүрдүүлэх материал:**
-Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын “Бусад” гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
-Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
-Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
-Урьд ажиллаж байсан байгууллага, хүмүүсийн тодорхойлолт
-Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн битүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны есдүгээр сарын 1-ний өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Хүний нөөцийн алба**
**Утас: 11 325802, 99771199**

# ЦАГ ҮЕ

ӨӨРӨӨС НЬ

# Д.ЦЭНГЭЛ: Монгол киног дэлхийд гаргах нэг гарц нь Киноны тухай бие даасан хуультай болох

Н.БАТЗАЯА

*Сүүлийн үед олон улсын кино наадамд “Монгол Улс”-ын гэх тодотголтой кино нэрээ дуудуулж, мянга мянган үзэгчдээс алга ташилт, урам зориг авч буй. Өөрөөр хэлбэл, 21 дүгээр зуун гарснаас хойш Монгол Улсад хаалттай байсан дэлхийн киноны зах зээл үүд хаалгаа нээсэн гэхэд болно. Харин энэхүү үйлсэд өөрийн хувь нэмрээ оруулан, монгол уран бүтээлчдээ бусад орны уран бүтээлчидтэй холбож, Монголоо, киногоо сурталчилж яваа нэгэн бол “Тэнгис” кино театрын Маркетингийн албаны дарга, СУИС-ийн багш, доктор, СТА Д.Цэнгэл. Тэрбээр энэ сард Филлипин улсад зохион байгуулагдсан олон улсын наадамд шүүгчээр ажиллаад зогсохгүй ганзага дүүрэн ирээд байгаа билээ. Ингээд түүнтэй ярилцсанаа хүргэе.*




**-Филлипин улс дахь олон улсын кино наадамд шүүгчээр ажилласан гэсэн. Энэ талаар ярилцлагаа эхэлье. Ямар онцлогтой наадам болов?**

-Филлипин улсад “Cinemalaya” олон улсын кино наадам 13 дахь жилдээ амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү олон жилийн түүхтэй кино наадамд шүүгчээр ажиллаад ирсэн. Уг наадмыг шүүх болсон шалтгаан гэвэл, би олон улсын “NETPAC” байгууллагын гишүүн. Манай байгууллагаас гишүүддээ олон улсын кино наадмыг шүүх томилолт өгдөг. Энэ хүрээнд би өнгөрсөн жил Өмнөд Солонгос улсад болсон олон улсын кино наадамд шүүгчээр ажиллаж байсан. Энэ жил Филлипин улсад ажиллаад ирлээ.

**-Кинонoос тухайн улсын ард иргэдийн амьдрал, соёл, хөгжлийг харж болдог гэдэг. Та шүүгчээр ажиллахаас гадна Монголынхоо дэлгэцийн бүтээлийг олон улсын кино наадамд сойход томоохон үүрэг гүйцэтгэдэг. Очсон улс болгоныхоо кино урлагтай холбоотой соёл, хөгжлийг судалж явдаг байх. Филлипин улс кино урлагаа хэрхэн дэмждэг вэ?**

-Би Филлипин улс руу анх удаа очсон. Их өвөрмөц соёлтой ард түмэн юм билээ. Надад маш их таалагдсан нэг зүйл нь гэвэл, Филлипин улс маш урт сунасан арлаас бүтдэг. Арлынхаа урд хэсгээр дайн дажинтай учраас тайван бус байдаг. Гэсэн хэдий ч кино урлагийг тасралтгүй хөгжүүлж, төрөөс нь дэмжиж ирсэн юм билээ. Ялангуяа кино урлагийг хөгжүүлэхэд Засгийн газраас нь авч хэрэгжүүлж байгаа бодлого нь их таалагдсан. Бүтэц нь их зөв юм билээ. Манай улстай зүйрлэхэд Соёлын төв нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болж ажилладаг. Тиймээс ч бүтэн жилийн турш хошин урлаг, драм, кино гээд урлагийн бүх л салбартаа төрөл бүрийн олон улсын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулдаг. Тэдгээрийн нэг нь “Cinemalaya” олон улсын кино наадам. Энэхүү кино наадмыг Засгийн газраас сан бүрдүүлж, санхүүжүүлдэг. Сангаас нь жил бүр 10 кино зохиолын төсөл шалгаруулж, 50 хувийн санхүүжилт олгох зарчмаар уран бүтээлчдээдэмжижажилладагнь их зөв санагдсан. Өөрөөр хэлбэл, уран бүтээлчид кино бүтээх зардлынхаа 50 хувийг улсаасаа, үлдсэнийг нь өөрсдөө олдог гэсэн үг. Гэхдээ зүгээр 10 төсөл шалгаруулаад, санхүүжилтийг нь өгөөд орхичихдоггүй. Шалгарсан төслийнхөө уран бүтээлч бүрт чиглэсэн сургалтыг бүтэн жилийн турш явуулдаг. Тухайлбал, жүжигчин, найруулагч, оператор, зураглаач гэх мэтчилэн хүн бүрийг сургалтад хамруулах ажлыг Засгийн газраас нь зохион байгуулна. Энэ маягаар дутууг нь нөхөж сайжруулдаг. Энэ нь анх кино хийж байгаа, хийхийг хүсч байгаа хүмүүст маш том дэмжлэг болдог. Харин жилийн дараа Засгийн газраас нь шалгалт авч байгаа юм шиг шалгарсан 10 киногоо дэлгэцнээ гаргаж, үзэгчдийг хүртээл болгодог. Ийм л бодлого хэрэгжүүлж, уран бүтээлчдээ дэмждэг юм билээ. Энэ бодлого нь ялангуяа шинэ залуу уран бүтээлчдийг ахиж, дэвшихэд нь маш том дэмжлэг болдог юм шиг санагдсан. Нөгөөтэйгүүр уран бүтээлчдийнхээ сэтгэхүйг хязгаарладаггүй юм билээ. Кино зохиолд ямар нэгэн аллага, хүчирхийллийг тусгахыг хориглодоггүй. Уран сайхны байдлаар юуг л бол юуг үзүүлж болно гэдэг. Маш чөлөөтэй, хязгаарлахгүйгээр гаргадаг. Ингэснээр уран бүтээлчдээ дэмжиж, үзэгчдийг ч татаж чадсан. Анх үзэгч байхгүй, их л хэцүү байсан боловч цаг хугацаа өнгөрөх тусам үзэгчидтэй болж чадсан юм байна лээ. Энэ удаагийн кино наадамд оролцсон уран бүтээлийг ч оюутан залуус сонирхож, маш их үзэж байсан. Энэ жил “Хүндлэл” нэртэй кино тэргүүн байранд шалгарсан. Бас нэг таалагдсан зүйл гэвэл, кино наадамд тэргүүн байр эзэлсэн уран бүтээлчдийнхээ цаашдын ажлыг нь дэмжиж, тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал олгож байсан. Мөн “Cinemalaya 2017” кино наадмын шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааны үеэр 2019 онд дэлгэцнээ гарах кино зохиолын төслийг шалгаруулсан.

**-Таван орноос Монгол киног олон улсын кино наадамд оролцуулах урилгатай ирсэн гэж сонссон. Ямар ямар улсаас урилга авав?**

-Аливаа олон улсын шинж чанартай кино наадам гэдэг өөрийн орны киног дэлхийн төвшинд хаана явж байна вэ гэдгийг мэдэж, шалгах боломж байдаг. Магадгүй би монгол кино наадмыг шүүвэл арай өөр өнцгөөс харна. Илүү таньдаг жүжигчнээ онцолж харах аль эсвэл энэ сайн найруулагч гэдэг өнцгөөс харах болов уу, монгол хүн учраас. Харин огт өөр соёлтой, өөр иргэншилтэй улсын тухайн салбараар мэргэшсэн хүмүүс ирээд киног нь шүүвэл чин шударгаар шүүх боломжтой. “Cinemalaya 2017” наадмын үеэр Сингапур, Хонгконг, Токио, Филлипин, Индонез улсын шүүгчидтэй хамтарч ажиллах боломж олдсон юм. Тэд монгол киноны талаар “15-20 жилийн өмнө та нар их идэвхтэй байсан. Сүүлийн үед сураггүй болсон байна. Дараа дараагийн кино наадамд монгол киног явуулаарай” гэж хэлсэн. Кино наадам гэдэг өнөөдөр киногоо явуулаад маргааш бүтчихдэг зүйл биш. Зургаан сараас нэг жилийн өмнө төлөвлөсний үр дүнд явуулдаг. Цаг хугацаа шаардагдсан ажил учраас 2018-2019 онд үр шим нь гарах байх.

> Би Монгол Улсад Киноны тухай хууль бий болоосой гэж хүсдэг. Гэхдээ хориглох биш, дэмжих хууль гараасай гэж боддог. Ер нь кино гэдэг маш их үзэл суртлыг түгээдэг зэвсэг учраас хамаагүй болж, бүтэхгүй зүйлийг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх аюул байдаг л даа. Мөн манай улс том соёлын нөлөөнд хэтэрхий их автаж байна.

**-Олон улсын кино наадам Монгол Улсаа бусад оронд сурталчилж, таниулах нэг гарц болов уу гэж харж байна. Манай улсад Япон, Солонгос, Чех киноны өдрүүд гэж болдог шүү дээ. Үүнтэй адил манай уран бүтээлчдийн кино ч өөр бусад орнуудад гарвал Монголын соёл, аж амьдрал, хөгжлийг сурталчилна шүү дээ. Энэ талаар ямар бодолтой байдаг вэ?**

-Энэ бол маш их боломжтой зүйл. Манай улсад Соёлын яам байдаггүй. Элчин сайдын яамдууд тухайн улсдаа Монгол орноо сурталчлах үүрэг хүлээдэг. Тиймээс Монгол киноны болон соёлын өдрүүдийг оршин суугаа улсдаа зохион байгуулаасай гэж боддог. Гэхдээ хийе гэхээр манай улсад тогтолцоо нь байдаггүй л дээ. Боловсролын яам, Соёлын



газартаа ханддаг ч Соёлын газар нь кино уран бүтээлчидтэйгээ харьцах агентлаг нь байдаггүй. Шууд киногоо үзүүлье гэхээр хаана, ямар зорилгоор гаргах нь мэдэгддэггүй. Энэ тогтолцоо тодорхой байсан бол илүү хамтын ажиллагаатай ажиллах боломжтой. Миний хувьд Монголын соёл урлагийг сурталчилах зорилготой “Соёлын дистрибьютер” гэдэг компани үүсгэн байгуулсан. Шүүх, олон улсын кино наадамд явуулах үйл ажиллагаа давхар хийж байна.

**-Сүүлийн үед зарим хүмүүс Монголд алтан үеийнхний кино зохиолыг гүйцэхээр сайн зохиол алга, илүү муу зүйлсийг залууст сурталчилж байна гэж ярьдаг. Одоогийн кино зохиол үнэхээр муу байна уу?**

-Би энэ талаар арай өөр байр суурьтай байдаг. Өнгөрсөн үе гоё, одоо үе муу. Тэр үеийнхэн сайн жүжигчин байсан, одоогийн жүжигчид хэрэг алга гэдэг. Цаг цагаараа байдаггүй, цахилдаг хөхөөрөө байдаггүй шүү дээ. Үе үеийн залуусын хүсэл сонирхол өөр байдаг. Тухайлбал, Холливудын киноны стандарт гэхэд нэг сайн залуу зовлонд учраад сайн үйлийн төлөө явдаг. Бүр эцэст нь тулгавал сүүлд нь нэг баатар гарч ирээд авардаг. Ийм ритмтэй кино үзсээр байгаад сурчихсан. Гэтэл солонгосчууд гэхэд уянгын халил ихтэй кино хийдэг. Тэгэхээр лам ламын уншлага өөр гэдэг шиг юу ч байж болно. Энэ дундаас шалгарч гарч ирэх нь ирээд бусад нь цагийн аясаар үгүй болно. Хамгийн гол нь мэргэжлийн хүмүүс маань л энэ салбартаа үлдээсэй гэж би хүсдэг.

**-Одоогийн кино урлагт, уран бүтээлчдэд хамгийн шаардлагатай байгаа зүйл нь юу байна вэ?**

-Би Монгол Улсад Киноны тухай хууль бий болоосой гэж хүсдэг. Гэхдээ хориглох биш, дэмжих хууль гараасай гэж боддог. Ер нь кино гэдэг маш их үзэл суртлыг түгээдэг зэвсэг учраас хамаагүй болж, бүтэхгүй зүйлийг сурталчилж, түгээн дэлгэрүүлэх аюул байдаг л даа. Мөн манай улс том соёлын нөлөөнд хэтэрхий их автаж байна. Эхлээд орос, дараа нь Холливудын кино их гарсан. Тэгээд Хонгконг, Солонгос кинонд үзэгчид орсон. Одоо зурагтаа асаагаад харахаар суваг бүрээр хятад кино гарч байна. Энэ нь цаагуураа соёлын дархлаа гэдэг зүйлийг устгадаг. Тийм учраас Соёлын яамаа байгуулаад, Киноны тухай хуулийг батлаад өгөөч гэж хүсмээр байна.

**-Засгийн газраас монгол киног дэмжинэ гэж ярьдаг ч бодит байдал дээр хэрэгждэггүй. Монгол киног дэлхийд гаргахад ямар асуудал тулгарч байна вэ. Нэг үеэ бодвол монгол кино олон улсын наадамд оролцож байна. Гэхдээ тийм ч амар гарчихдаггүй болов уу?**

-Манайулсынмэргэжлийнуран бүтээлчид олон улсын наадамд оролцоход дансандаа мөнгө байршуулдаг. Уран бүтээлчид мөнгөө байршуулчихдаг. Харин чөлөөт уран бүтээлч гэхээр түүнийгээ батлаад ир гэдэг. Энэ хүн чөлөөт уран бүтээлчээр ажилладаг гэдгийг батлах ямар ч газар байдаггүй. Нийгмийг хаашаа явахыг залдаг хэсэг бүлэг хүмүүс байна. Тэднээс татвар аваач, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэж өгөөч. Тоглолт зохион байгуулаад, кино бүтээгээд хаанаас хэдэн төгрөгийн орлого олж байгааг хянадаг болмоор байна шүү дээ. Зүгээр л чөлөөт зах зээл гээд мөнгө эргэлддэг. Мөнгөний хажуугаар сайн, муу зүйл олон байна.

**-Манай улсад кино бүтээлээ гэхэд ямар ч татвар төлдөггүй гэсэн үг үү?**

-Яах вэ, театр, компанитайгаа хамтран ажилладаг. Гэхдээ тухайн уран бүтээлч кинонд тоглолоо гэхэд хэдэн төгрөгийн гэрээ хийж байгааг батлах газар байхгүй. Хэрвээ батлаад, татвар төлчихдөг байсан бол тухайн хүнийг “Энэ хүн бол чөлөөт уран бүтээлч. Тэндээс олсон орлогоороо нийгмийн даатгалаа төлдөг” гэх мэтчилэн батлагдах боломж нь байдаг. Нэг нь ч төл гэдэггүй, нөгөөдөх нь ч төлдөггүй. Эргээд гадагшаа гарах гэхээр нийгмийн статус нь их саад болдог.

ТОМИЛОЛТ

# 21 аймгийн бизнес эрхлэгчид олон улсын үзэсгэлэнд оролцов

Н.ЗАЯА





“Манжуур хотын худалдаа, хөрөнгө оруулалтын экспо 2017” энэ сарын 18-20-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотноо амжилттай болж өндөрлөлөө. Гурван жил тутамд нэг удаа зохион байгуулагддаг уг үзэсгэлэн худалдаанд нийт 20 гаруй орны бизнес эрхлэгчид оролцон бараа бүтээгдэхүүнээ танилцуулав. Тус үзэсгэлэнд Монгол Улсаас УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар, МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Б.Лхагважав, үндэсний үйлдвэрлэгч томоохон компани болон 21 аймгийн бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцлоо. Энэ үеэр МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Б.Лхагважав “Зүүн хойд Азийн хөгжлийн төв Манжуур хотыг чиглэж байна. Тиймээс ч энэ үзэсгэлэн Манжуур хотод болж байна. Энэхүү үзэсгэлэнгийн нэг зорилго нь гурван улсын бизнес эрхлэгчдэд хоорондоо түншийн харилцаа тогтооход нь туслах зорилготой. Манай улсаас 11 салбар болон төв танхимынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байна. Мөн ОХУ-ын Уралаас наашхи бүх танхимын төлөөлөгчид, Манжуур, БНХАУ-ын төлөөлөгчид форумд оролцож байна. “Нэг бүс нэг зам”-ыг барих нь улс төрийн маш том шийдвэр байсан. Нөгөөтэйгүүр хөрөнгө оруулалтын том асуудал юм. Харин үүнийг худалдаа эрхлэгч, бизнесмэнүүд гүйцэтгэнэ. Томоохон бизнес эрхлэгчид энд анхаарал тавих нь чухал байна. Ер нь үндсэн зах зээл хил дагуух бүсүүдэд Сүүлийн жилүүдэд бид олон улсын үзэсгэлэн худалдаанд ихээхэн анхаарч байгаа. Олон улсын шинж чанартай үзэсгэлэнгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн захиргааны ямар нэгэн хүндрэлгүй орж ирдэг. Цаашид ч 365 хоног үзэсгэлэнд оролцож байгаа мэт хөнгөлөлттэй ордог байх хэрэгтэй. Энэ талаар бид БНХАУ-ын талтай ярилцаж байна” гэв. Харин УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар “Энэхүү үзэсгэлэн худалдаа бол хоёр орны стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлж буй нэг хэлбэр. Дарга нар хоорондоо асуудал ярихдаа бус энгийн ард иргэд худалдаа хийж, бие биедээ тус дэм болж явахыг л хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, уг үзэсгэлэнд оролцож бараа бүтээгдэхүүнээ борлуулахаас гадна цаашид хамтран ажиллах түншгэй болох нь чухал. Энэ мэтчилэн зохион байгуулалттайгаар өөрийн орны бараа бүтээгдэхүүнийг шинэ зах зээлднэвтрүүлж, хэрэглэж сургаж байна гэсэн үг. Харин уг ажлыг төр, төрийн бус байгууллага, танхимтай хамтран хийх нь чухал байна” гэлээ.

## ЗАВСАРЛАГА

Books “Ном” буланд тавтай морил

# ИХ ГЭРИЙН ЭЗЭГТЭЙ

**Түрүүч нь №141 дугаарт**
**Үргэлжлэл**

Залуу эр 18 цаг сэрэхгүй унтав. Жемийг сэрэхэд хамаг бие нь янгинан өвдөх боловч цээжнийх нь гүнд баясгалангийн дуу эгшиглэж, “Би хүрээд ирлээ. Хэрэг бүтлээ” хэмээн бодов. Тэр өлсөж үхэх гэж байгаагаа мэдээд хоол эрэхээр гарлаа. Зочид буудалд нь хоол өгдөггүй, эсрэг талд нь жижиг гуанз байдаг аж. Жеми тэр пиг дүүрэн хүнтэй гуанзанд орж, шорлож шарсан хонины мах, харахад цурхай болов уу гэж таамагламаар шарсан загас цуварга мах захиалж, даруулах амттан зуушинд жимсэн чөмөгтэй боов захиалав. Жеми юм идээгүй удсанаас гэдэс нь өвдөж байлаа. Үлдсэн хоолоо байзнаж байгаад идэхээр хойш тавьж, эргэн тойрноо харав. Ширээнүүдийн ард эрэлчид суугаад хэн бүхний сэтгэлд ойр сэдэв болсон алмасны тухай хөөрөн шуугилдаж байв.

-Хоуптауны ойролцоо жаахан алмас үлдсэн. Гол нь орд нь Нью Рашид бий...

-Йобургийг бодвол Кимберлид хавьгүй их бий...

-Түрүү долоо хоногт Дутоиспаниас юу олдсоныг дуулсан уу? Тэнд дааж авчирахын талгүй их алмас байна гэж дуулдсан...

-Кристианд шинэ орд олсон гэнэ. Би маргааш тийшээ явна. Энэ мэтээр шуугилдана. Олны яриа үнэн байжээ. Энд газар сайгүй алмас эрдэнэ байдаг юм байна. Жемийн сэтгэл хөөрөн догдолж, аяга кофег арай гэж гүйцээн уув. Хоолны үнийг төлөх болоход 2 фунт 10 шиллинг гэснийг сонсоод гайхаж хоцорлоо. Ганц амиар энэ шүү. Хөл үймээн ихтэй гудамжинд гарч ирээд “Мөнгөө хямгадах хэрэгтэй юм байна” гэж бодлоо. Ард нь нэг хүн,

-Баяжих гэж хүсэн мөрөөдсөөр үү, Макгрегор? гэхэд нь эргэж харвал энд хамт ирсэн Петтерсон байлаа.

-Тэгэлгүй яах вэ...

-Тэгвэл алмастай газар очицгооё. Вааль голын цаад талд гэж Петтерсон хэлээд гараараа заав. Тэр хоёр замаар орон алхлаа. Клипдрифт эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн нам газар оршино. Өвс ногоо үл үзэгдэнэ. Агаарт улаан тоос босоод амьсгалахад маш хэцүү. Вааль гол эндээс j милийн зайтай урсах бөгөөд ойртон очиход аятайхан сэрүү татаад ирэв. Голын хоёр талаар олон зуун эрэлчид байрлаж, зарим нь газар ухаж, нөгөө хэсэг нь чулуу элгэгдэж, гурав дахь хэсэг нь бүдүүн хийцтэй ширээн дээр чулууг ялгаж байлаа. Тоног төхөөрөмж нь шороо угаах машинаас эхлээд модон хайрцаг, төмөр хүрз хүртэлх янз бүрийн зүйл байх ажээ. Эрэгтэйчүүд нь сахал үсээ хусаагүй, арьс нь наранд түлэгдэн барзайсан байх агаад захгүй судалтай тэрмэн цамц, тансар хилэн өмд, резинэн гутал, өргөн хүрээтэй эсгий малгай өмсцгөөжээ. Бүгдээрээ алмас юм уу, мөнгө хийх ууттай өргөн ширэн бүс бүсэлсэн байлаа. Жеми, Петтерсон хоёр голын хөвөөгөөр явж байгаад нэгэн залуу хөвгүүн, өвгөн хоёр хайрга чулуунд хүрэхийн тулд лут том үхэр чулууг байрнаас нь хөдөлгөх гэж ноцолдож байгааг үзэв. Тэдний цамц нь хөлс нэвтэрчээ. Хажууд нь өөр хоёр хүн жижиг тэргэнцэрт хайрга ачиж байв. Нэгэн эрэлчин хайрцаг сав ганхуулж, нөгөө нь лагийг арилгах гэж хувингаар ус цутгаж байв. Дараа нь том чулууг өөрсдөө хийсэн ширээн дээр ялгаж, нарийн нягт үзэж гарлаа.

-Ийм амархан байдаг байна шүү гэж Жеми жуумалзахад,

-Амархан юм шиг санагддаг нь худлаа. Би энд ирээд удаж байгаа улс амьтантай ярьж үзлээ. Бид ийшээ дэмий ирсэн шиг санагдаж байна гэв.

-Чи юу хэлэх гээд байна вэ?

-Энд баяжих хүсэлтэй хэдэн хүн газар ухаж байдаг гэж бодно вэ? Хорин мянга, чөтгөр алгад. Бүгдэд хүрэх алмас энд байхгүй. Хүрдэг юм аа ч гэсэн зүтгээд зүтгээд нэмэр байгаа юм уу даа гэж эргэлзэх боллоо. Өвөл нь халуунд халж, зун нь хүйтэнд хөрж, тондерстормд шалба цохиулна. Тоос шороо, ялаа батгана, өмхий самхай... Бие угаачих, аятай тохитой унтчих газар ч байхгүй, балиар муухай нь дэндүү. Долоо хоног бүр Вааль голд хүн үхдэг гэнэ. Зарим нь санамсаргүй. Ихэнхийн хувьд энэ бол эндээс явах цорын ганц зам гэнэ. Энэ хүмүүс боож үхэхгүй яаж тэсдэг юм бэ, бүү мэд гэхэд нь Жеми бохир муухай цамцтай залуу эрийг хараад,

-Би мэднэ. Эд нар одоо ингээд аз таарна гэж горьдож байгаа гэв.

Хот руу буцаж явах замдаа Петтерсоны хэлсэн үнэн юм байна гэдгийг Жеми арга буюу зөвшөөрөх хэрэгтэй болов. Жорлонгийн оронд жорлон болдог өргөн шуудууны хажуугаар газар сайгүй хонь, ямаа, үхрийн яс цайран харагдана. Өмхий самхай нь тэсэхийн аргагүй. Петтерсон түүнийг ажиглаж байснаа,

-Чи одоо яах гэж байна вэ? гэсэнд

-Эрэлчийн багаж хэрэгсэл худалдаж авна гэв. Хотын төвд зэв идсэн хаяг дээр “Саломон ван дер Мерве, бараа таваар” гэсэн нэгэн дэлгүүр байв. Жемитэй нас ойролцоо өндөр негр залуу дэлгүүрийн хаалганы өмнө тэрэгнээс ачаа буулгаж байв. Өргөн ханагар цээжтэй, булчин шөрмөс нь зангирсан тэр негр залуугийн сайхныг Жеми гайхав. Тэр бол хар нүдтэй, бүргэд хамартай эрэмгий байрын эрүүтэй залуу байлаа. Харваас эр чадал, нэр сүрдээ итгэсэн байдал мэдэгдэнэ. Негр залуу буутай том хайрцаг үүрэн эргэхдээ байцааны навч дээр хальтирхад нь Жеми өөрийн эрхгүй түшихээр гар сунгасан боловч негр залуу түүнийг хүн гэж тоож анзаарсангүй, цааш эргэн дэлгүүр рүү орлоо. Хажуугаар нь явж байсан луустай африк эр жигшин зэвүүцсэн байдалтай газар нулимаад,

-Энэ Банда баролонг овог аймгийн хүн. Мистер Ван Дер Мервегийн гарын дор зарагддаг юм. Энэ банту овгийнхон ертөнцийг эзэгнэсэн юм шиг боддог байх аа. Мистер Ван Дер Мерве энэ их зантай харыг яах гэж дэргэдээ авч байдаг юм бэ, бүү мэд гэжээ.

Дэлгүүр дотор гэрэл муутай, сэрүүхэн. Халж цооносон шуугиант гудамжнаас энд орж ирэхэд таатай байлаа. Энд бас ер бишийн үнэртэй юм. Эндэхийн ямх бүрт бараа таваар дүүрэн чихээстэй байх шиг



Жемид санагдав. Тэгээд дэлгүүр дотор өөрийн ухаангүй болсон мэт явж байлаа. Энд хөдөө аж ахуйн бордоо, пиво, сүү, тостой хайрцаг, цемент, тэсрэх бодис, дарь, хогшил тавилга, ваар шаазан, дэнлүү, оо, саван, архи дарс, бичгийн хэрэгсэл, тамхи тэргүүтэн байв. Арван хэдэн тавиурын дээрээс доор хүртэл тэрмэн цамц, хөнжил, шаахай,суран бүс дүүрэн өржээ. “Энэ бүхний эзэн нь их баян хүн байж таарна” гэж Жеми бодов. Ард нь эмэгтэй хүний зөөлөн дуугаар,

-Танд юугаар тус болох вэ? гэх нь сонсогдлоо.

Жеми эргэж хараад нэгэн бүсгүйтэй нүүр нүүрээрээ тулгарав. Харахад нас 15 орчим болов уу гэмээр. Нүүрний хэлбэр нь өвөрмөц сонин, дурлалын ил захидал дээр байгаа зүрх шиг. Буржгар хар үстэй, шантгар хамартай, хурц ногоон нүдтэй ажээ. Жеми охины биеийн хэлбэр галбирыг сайн хараад нас 16 хүрч байгаа болов уу гэж бодлоо.

-Би эрэлчин. Зарим нэг багаж хэрэгсэл худалдаж авмаар байна гэж Жеми охинд хэллээ.

-Танд юу хэрэгтэй вэ? гэхэд нь Жеми яагаад ч юм бэ энэ бүсгүй нүдэнд аятайхан харагдахыг хичээж,

-За даа ... ердийн юм гэсэнд бүсгүй нүдээ зальтайхан нүдээ онийлгон инээмсэглээд,

-Ердийн юм гэдэг чинь юу гэсэн үг вэ, эрхэм ээ? гэхэд нь Жеми түгдэрч,

-За... Хүрз хэрэгтэй.

-Ердөө энэ үү?

Бүсгүй өөрийг нь даапаалж байгааг Жеми мэдээд цагаан сэтгэлээр талбиун инээмсэглэв.

-Үнэнээ хэлэхэд би шинэ хүн болохоор надад юу хэрэгтэйг мэдэхгүй байна гэсэнд бүсгүй хариу инээмсэглэв.

-Энэ ч таны юу эрэхээс л болно доо, мистер?

-Намайг Жеми Макгрегор гэдэг.

-Би Маргерет Ван Дер Мерве байна хэмээн бүсгүй хэлээд дэлгүүрийн цаад тал руу сэтгэл түгшсэн янзтай харав.

-Мисс Ван Дер Мерве тантай танилцсандаа баярлаж байна.

-Та хэзээ ирээв?

-Аа-хн. Өчигдөр ирсэн. Шуудангийн тэргээр.

-Тийм хэцүү аян замд дайгдаж яваа хүмүүс үхдэгийг танд хэлээгүй юм уу? гээд бүсгүйн нүдэнд хилэнгийн оч гялсхийв. Жеми инээмсэглэн,

-Тэдэнд гомдох юм алга. Харж байгаа биз дээ, би эрүүл энх байж байна гэсэнд,

-Та “мой клиппе” эрэх гэж байгаа юм уу?

-Мой клиппе гэж юу юм бэ?

-Алмас эрдэнийг голландаар ингэж хэлдэг юм. Гялалздаг чулуу гэж.

-Та голланд хүн үү?

-Манай гэрийнхэн Голландынх.

-Би Шотландаас ирсэн.

-Мэдэгдэж байна гээд бүсгүй дэлгүүрийн цаад тал руу дахин сэтгэл түгшсэн янзтай харснаа,

-Энд алмас бий, Мистер Макгрегор. Харин байгаа газрыг нь мэдэх хэрэгтэй. Олон эрэлчин энд хий дэмий үйлээ үзэж тамаа цайж байдаг. Ганц нэгхэн хүн орд газар олж, бусад нь шавар шавхай ухаж байдаг. Хэрэв та баяжихыг хүсч байгаа бол өөрийн орд газрыг олох ёстой.

-Яаж олох гэж?

-Манай эцэг танд туслаж чадахсан. Бүгдийг мэддэг. Цагийн дараа завтай болно.

-Би эргээд ирнэ. Мисс Ван Дер Мерве танд баярлалаа.

Жемигийн сэтгэл хөөрөн баясаж, зовлон зүдгүүрээ мартаад нар гийсэн гудамжинд гарав. Саломон Ван Дер Мерве алмас эрэх газрыг зааж өгвөл Жеми алмас олохдоо л олно. Тэгээд удахгүй баяжихыг зөгнөсөн залуу хүний баясгалант инээдээр тас тас инээв. Жеми гол гудамжаар дархны газар, биллъярдын танхимын дэргэдүүр өнгөрсөн нэг муу байшингийн дэргэд очив. Хаягийг нь уншвал “Миллерийн халуун, хүйтэн ус. Өдөр бүр 06.00-20.00 ажиллана. Хувцас тайлах газар нь тохилог” гэжээ. “Би сүүлчийн удаа биеэ хэдийд угаалаа. Хөлөг онгоц дээр хувин усаар биеэ булхсан. Хэдийд билээ дээ, байз...” гэж Жеми бодоод өөрөөс нь муухай үнэр ханхалж байгааг сэтгэлдээ төсөөлөв. Өөрийн шотланд гэрийн гал тогоонд өдөр бүр биеэ угаадаг байснаа санав. Халуун усны газрын үүдийг онгойлгон дотогш орлоо. Дотроо хоёр хаалга байгаагийн нэг нь эрэгтэйчүүдийнх, нөгөө нь эмэгтэйчүүдийнх ажээ. Жеми эрэгтэйчүүдийн тасагт ороод хижээл насны үйлчлэгчид хандан,

-Усанд ороход ямар үнэтэй бэ? гэсэнд

-Хүйтэн усанд бол 10 шиллинг, халуунд бол 15 шиллинг гэжээ. Жеми бодол болов. Уг нь халуун усанд орвол сайхансан. Даанч мөнгөө хамаагүй үрж болохгүй. Багаж хэрэгсэл авахад мөнгө хэрэгтэй.

-Хүйтэн усанд орьё гэж хэлсэнд үйлчлэгч түүнд хуучин муу алчуур өгөөд,

-Ийшээ орогтун, ай хөө гэлээ.

Жеми нэг умгар өрөөнд орвол гол дунд нь том цайран онгоц, хананд нь хадсан дэгээнээс өөр юм байсангүй. Үйлчлэгч гэх хар хүн онгоцыг модон торхноос ус авч дүүргээд,

-Бэлэн боллоо, мистер ээ. Хувцсаа тэр дэгээнээс өлгөж болно гэжээ.

Үйлчлэгчийн гарахыг хүлээж байгаад Жеми хувцсаа тайчин хир буртаг шивсэн биеэ нэг харж, онгоцонд өрөөсөн хөлөө дүрж үзвэл үйлчлэгчийн хэлснээр ус нь хүйтэн байлаа. Жеми шуд зуун онгоцонд орж, хөлөөс толгой хүртэл сайтар савандаж биеэ угаав. Онгоцноос гарахад ус нь хар болсон байв. Үйлчлэгчийн өгсөн уранхай алчуураар биеэ арчаад хувцсаа өмсөв. Хир даг болсон өмд, цамцаа өмсмөөргүй санагдана. “Дотуур хувцас авах хэрэгтэй юм” гэж бодоод хэчнээн бага мөнгө үлдсэнийг саналаа. Тэгтэл бас гэдэс нь өлсөж байдаг. Жеми халуун усны газраас гараад хөл ихтэй гудамжаар явж, “Тэнүүлчин” нэртэй гуанзанд орлоо. Ороод хоол, пиво захиалсанд улаан лоолийн хачиртай хонины хавирга, төмсөн шанцай, давсалсан өргөст хэмхтэй зайдас авчирч өглөө. Хоол идэж байх зуур зэргэлдээх ширээнийхний яриаг чагнавал,

-Колсбэргийн тэндээс 21 кратын алмас олдсон гэнэ. Тийм алмас тэнд зөндөө байдаг гэнэ...

-Херборид шинэ орд олсон гэнэ. Би тийшээ явах санаатай...

-Ээ тэнэг. Шар мөрөнд л хамгийн том алмас бий...

Баарны лангууны тэнд тансар хилэн өмд, тэрмэн цамцтай, бавгар сахалтай нэгэн эр том хундагатай пиво барин зогсоод баарны хүнд хандан,

-Би Хеброн орно. Багаж хэрэгсэл, хоол хүнс хэрэгтэй байна гэж итгэмжлэн хэлж байгаа нь сонсогдов. Баарны хүн, хугарч нахийсан хамартай, гөлөлзсөн нүдтэй бүдүүн халзан эр тас тас хөхөрч,

-Хэнд ч тийм юм хэрэгтэй. Чи намайг яагаад энэ баарand байж байна гэж бодоо вэ? Хүрэлцэх хэмжээний мөнгө олмогцоо Шар мөрөн рүү явна. Чамд гэж хэлэхэд Саломон Ван Дер Мерве дээр оч. Дэлгүүрийн эзэн, энэ хотын тэн хагаст эзэн сууж буй хүн шүү гэж тэр хэлээд баарны лангууг муухай алчуураар арчив.

-Тэр чинь надад ямар хэрэгтэй юм бэ?

-Хэрэв чи түүнд тоогдвол чамд туслана гэсэнд бүдүүн халзан эр өөдөөс нь гайхан ширтэж,

-Тийм үү? Нээрээ туслаж чадах юм уу?

-Хэдэн залууд тусалсныг нь би мэдэх юм. Чи биеийн хүчээ үнэлж, тэр чамд хөлс мөнгө өгнө. Ашгаа тэхий дундуур нь хуваана.

Жеми шамдан бодож эхлэв. Урьд бол үлдсэн 120 фунтээрээ багаж хэрэгсэл, хүнсний зүйл авч хүрнэ гэж бодож байжээ. Гэтэл Клипдрифтэд юмны үнэ тэнгэрт хадсан байлаа. Ван Дер Мервегийн дэлгүүрт 100 фунтын жинтэй нэг шуудай австрали гурил 5 фунтын үнэтэй байдгийг Жеми харсан юм. Фунт сахар нэг, лонх пиво тав, нэг фунт жигнэмэг гурван шиллинг бол 12 өндөг долоон шиллингийн үнэтэй. Юмны үнэ ийм байхад мөнгө дорхноо урсаад дуусна. “Тэнгэр минь, Энд гурван орой хоол идэх мөнгөөр манай гэрийнхэн бүтэн жил амь зууж хүрэхсэн” гэж Жеми бодлоо. Харин Ван Дер Мерве ч юм уу, ямар нэгэн чадал чинээтэй хүн туслах юм бол... Жеми хоолныхоо мөнгийг бушуухан төлөөд дэлгүүрт очихоор яарлаа. Саломон Ван Дер Мерве лангууны ард модон хайрцагнаас буу гарган зогсож байв. Тэр бол шөвгөн нүүртэй, нүүрээ тойрсон өтгөн хууз сахалтай жижигхэн хүн байлаа. Үс нь сүрлийн өнгөтэй, нүд нь онигор хар, хамар нь монцгор, уруул нь жимбэгэр. “Охин нь эхтэйгээ адил юм байлгүй дээ” гэж Жеми бодлоо.

-Уучлаарай, эрхэм ээ? гэсэнд Ван Дер Мерве толгойгоо өргөн,

-За? гэлээ.

-Та мистер Ван Дер Мерве юу? Намайг Жеми Макгрегор гэдэг. Шотландаас алмас эрхээр ирсэн юм.

-Тэгээд юу гэж?

-Таныг заримдаа эрэлчдийг санхүүжүүлдэг гэж дууллаа.

-Чөтгөр алгад гэж, хэн тийм цуурхал гаргадаг байна вэ? Ганц нэг эрэлчинд туслахтай зэрэг намайг өгөөмөр баян өвлийн өвгөн гэж боддог байна шүү гэж Ван Дер Мерве дургүйцэн бөвтнөв.

-Надад 120 фунт бий. Энд энэ мөнгө маань хүрэлцэхгүй юм байна. Хэрэв аргагүйд тулбал би ганц хүрз бариад алмас эрэхээр явна. Гэхдээ луус, багаж хэрэгсэлтэй явбал миний алмас олох боломж ихсэнэ гэж бодож байна хэмээн Жемийг шамдан өгүүлэхэд Ван Дер Мерве онигор хар нүдээрээ Жемийг анхааралтай ширтэн харж,

-Ээ тэнгэр минь, алмас олно гэж чи яаж мэдсэн юм бэ?

-Би дэлхийн хагасыг тойрч байж наашаа ирсэн. Баяжихаас нааш буцах бодолгүй байна. Энд алмас байдаг л юм бол би олно. Хэрэв та надад тусалбал бид хоёр хоёулаа баяжина.

Ван Дер Мерве хамар доороо хүнгэнээд буруу харж, модон хайрцагнаас буу гаргах ажлаа үргэлжлүүлэв. Жеми юу хэлэхээ мэдэхгүй хайвганан зогсож байлаа.

**Үргэлжлэл дараагийн дугаарт**


